



ХҮРТЭЭМЖТЭЙ САНХҮҮ

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОВХИМОЛ

2024 – 05 САР I ДУГААР 66

ГАРЧИГ

2–3 Бодлогын нийтлэл

4–7 Зохицуулалтын мэдээ

8–9 Байр суурь

10–12 Тогтвортой санхүүжилт

13 Компанийн засаглал, комплайнс

14–15 Финтек ба регтек

16–26 Судлаачийн индэр

27–28 Даатгалын хураамж гэж юу вэ?

29–31 Олон улсын зах зээлийн мэдээ

32 Олон улсын хөрөнгийн зах зээлийн индекс

БАЙГАЛЬД ЭЭЛТЭЙ 10 ШИЛДЭГ ФИНТЕКИЙН ЧИГ ХАНДЛАГА

Сэтгүүлийн энэ удаагийн дугаараар та бүхэнд 2024 онд бүх төрлийн аж ахуйн нэгж, байгууллага болон бизнес эрхлэгчдийн анхаарал хандуулж буй чухал асуудал болох тогтвортой байдлын талаар мэдээ мэдээлэл хүргэхээр бэлтгэлээ. Тогтвортой байдал нь финтекийн салбарт ч мөн адил хамаарах асуудал бөгөөд сүүлийн үед тогтвортой байдлын туршлагыг нэвтрүүлэх хэрэгцээ илүү чухал болж байгааг дурдах нь зүйтэй болов уу.

Fintech magazine-аас эрхлэн гаргадаг ШИЛДЭГ 10 нийтлэлийн хүрээнд финтекийн салбарт тогтвортой практикийг бий болгож буй хамгийн нөлөө бүхий чиг хандлагуудыг хүргэх болно.

Саяхан Лондон дахь QEII төвд Sustainability LIVE Net Zero 2024 арга хэмжээ болж, санхүүгийн тэргүүлэгч байгууллагууд ногоон ирээдүйн төлөө хэрэгжүүлж буй санаачилгуудыг олон нийтэд танилцуулсан. Энэхүү шилдэг 10 нийтлэлд тогтвортой байдлын зорилтыг дэмжихийн тулд өнөөдөр финтекийн салбарт ашиглагдаж буй тэргүүлэх туршлага, инновац, бүтээгдэхүүний талаар авч үзжээ.

10. НОГООН ЗЭЭЛ БОЛОН ТОГТВОРТОЙ САНХҮҮЖИЛТ

Хэрэглэгчид болон бизнес эрхлэгчид санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчдээсээ илүү тогтвортой бүтээгдэхүүн, үйлчилгээг авахыг шаардаж байгаа тул банкнууд болон бусад санхүүгийн байгууллагууд тогтвортой байдалд анхаарлаа хандуулахад түлхэц өгөх зээлийн бүтээгдэхүүнүүдийг санал болгож байна. Эдгээр зээлүүд нь эрчим хүч хэмнэх технологи, тогтвортой газар тариалангийн арга гэх мэт зүйлд хөрөнгө оруулалт хийдэг бизнесүүдэд бага хүү зэрэг бусад урамшуулал хөнгөлөлтийг олгож байна. Ногоон санхүүгийн хөтөлбөртэй банкнуудад HSBC-ийн Green Hub, Lloyds' Clean Growth Financing Initiative, Barclays' Green Loan зэрэг багтдаг.






ТАНЫ САНХҮҮГИЙН МЭДЛЭГТ

ИЛ ТОД БАЙДАЛ

Төрийн захиргааны ил тод байдал гэдэг нь холбогдох мэдээлэл иргэдэд ойлгомжтой, нээлттэй, засгийн газрын дүрэм журам, шийдвэр тодорхой, хүртээмжтэй байх тухай асуудал юм. Ил тод байдал бол хариуцан тайлагнах тогтолцоог жинхэнэ утгаар нь хэрэгжүүлэх урьдчилсан нөхцөл болж урьдчилан мэдэхүйц байдлыг бататгаж өгдөг.



TRANSPARENCY

Transparency in public administration means that relevant information is made available to the general public in usable form, and that government regulations and decisions are clear and adequately disseminated. Transparency is a prerequisite for genuine accountability and reinforces predictability.

Эх сурвалж: Засаглалын үзэл баримтлал, нэр томъёоны тайлбар толь бичиг

БОДЛОГЫН НИЙТЛЭЛ

ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООДЫГ ТӨРИЙН БОДЛОГООР ДЭМЖИХ НЬ



Банкны салбар нь хөрөнгийн шилжүүлэг, гүйлгээ, төлбөр тооцоонд чухал үүрэг гүйцэтгэж, хөгжиж буй орнуудын хувьд эдийн засгийн хөгжлийн үндсийг тавихаас гадна бичил санхүүжилт олгох замаар санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэхэд онцгой үүрэгтэй. Албан ёсны санхүүгийн байгууллагаас үйлчилгээ авах нь үр дүнтэй бөгөөд аюулгүй боловч бичил, жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчид

болон бага, дунд орлоготой иргэд, ялангуяа алслагдсан орон нутгийн иргэд барьцаа хөрөнгөгүй, зээлийн түүхгүй, орлогоо нотолж чадахгүй байдал зэргээс шалтгаалан албан сектороос зээл авах боломжгүйд хүрч, өндөр өртөгтэй албан бус секторт найдахаас өөр аргагүй байдалд хүрдэг.

Уламжлалт банкны үйлчилгээний гадна үлдсэн бага орлоготой иргэдэд бичил зээлийг хүртээмжтэй болгоход бизнесийн болон санхүүгийн мэдлэг олгох сургалт мөн зөвлөн туслах үйлчилгээнүүдийг дагалдуулах шаардлага үүсдэг. Иймээс банкнууд бичил, жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийг хэт өндөр өртөгтэй бизнесийн түнш гэж үзэх нь бий. Тэдэнд бичил зээл олгоход том корпорациудад зээл олгохоос ч илүү олон ажилтан шаардлагатай болохоос гадна ажилтнууддаа зээлийг шийдвэрлэхэд шаардлагатай ур чадвар, мэдлэг олгохын тулд нэмэлт эх үүсвэр зарцуулах шаардлага тулгардаг. Зардал, нөөцийн хязгаарлалтын улмаас энэ сегментэд үйлчлэхэд хүндрэлтэй байдаг гэж банкнууд үздэг тул бичил санхүүгийн байгууллагуудыг зохистой байдлаар хөгжүүлэх нь улс орнуудын хувьд санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэхэд сорилт болсоор байна.

Манай орны хувьд хүн ам цөөтэй, өргөн уудам газар нутагтай тул хүн амын нягтрал бага боловч нийслэл хотод хүн амын тал нь оршин суудаг. Байгалийн баялаг ихтэй хэдий ч Олон улсын валютын сан (IMF)-ийн 2023 оны тооцооллоор хүн амын амьжиргааны түвшин буюу нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүн 5,670.0 ам.доллар, дэлхийн дундаж 13,360.0 ам.доллароос 2.4 дахин бага. Дэлхийн банк (WB)-ны судалгаагаар 2022 онд Монгол Улсын нийт хүн амын 27.1 хувь буюу хүн амын гуравны нэг орчим нь ядуурлын түвшинд байна гэсэн үр дүн гарсан. Эдгээр хүмүүст санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх замаар эдийн засгийн үр бүтээлтэй үйл ажиллагаа эрхлэх боломжийг олгосноор тэдний нийгэм, эдийн засагт оруулах хувь нэмрийг нэмэгдүүлэхээс гадна тэд амьдралын чанараа сайжруулж, ядуурлаас гарах боломжтой болно.

Азийн хөгжлийн банк (ADB)–ны судалгаагаар 2018 онд “Монголын ихэнх бизнес эрхлэгчид бичил, жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчид бөгөөд тэдний ихэнх нь зээл, санхүүгийн үйлчилгээ авахад бэрхшээлтэй байдаг. Бүртгэлтэй аж ахуйн нэгжүүдийн 90 хувь, нийт ажлын байрны 50 орчим хувийг бичил, жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчид эзэлдэг ч улсын хэмжээнд 36,800 орчим бичил, жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн 90 хүртэлх хувь нь банкнаас тогтмол санхүүжилт авч чадахгүй байна. Энэ нь тэдний ажиллах, өсөх, эдийн засагт хувь нэмрээ оруулах боломжийг хязгаарлаж байна.” гэсэн дүгнэлтийг гаргасан. Мөн Олон улсын валютын сан (IMF)–ийн 2021 оны судалгаагаар дэлхийн хэмжээнд бичил, жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн тал хувь нь хэрэгцээтэй зээлээ авч чадахгүй байгаа нь том цоорхойг үүсгэж байна гэжээ. Бичил, жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн зээлийн эрэлт, нийлүүлэлтийн зөрүүтэй байдал манай улсад ч хамааралтай.

Энэ орон зайг нөхөж чадах санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчид бол бичил санхүүгийн байгууллагууд юм. Хадгаламж татдаггүй тул банк бус санхүүгийн байгууллагууд эргэлтийн хөрөнгийн дутагдалтай тулгардаг. Харин хадгаламж, зээлийн хоршоо зөвхөн гишүүддээ үйлчилдэг, гишүүд энэ байгууллагын өмчлөгчид байдаг. Банкнууд хөрөнгө оруулагчдын ашгийг нэмэгдүүлэхийг эрмэлздэг бол хадгаламж, зээлийн хоршоод гишүүддээ бага хүүтэй зээл, өндөр хүүтэй хадгаламжийн үйлчилгээ үзүүлэх замаар гишүүдийнхээ үр ашгийг нэмэгдүүлэхийг эрмэлздэг. Иймд хадгаламж, зээлийн хоршооны салбарын эрүүл хөгжлийг дэмжих замаар албан зээлийн хүртээмжийг нэмэгдүүлэх нь чухал болохыг харуулж байна. Алслагдсан бүс нутаг, хүмүүст хүрч санхүүгийн төрөл бүрийн үйлчилгээ үзүүлэх боломжтой байдал нь хадгаламж, зээлийн хоршооны давуу тал болно. Хадгаламж, зээлийн хоршоодыг дэлхий даяар зөв хөгжүүлэх нь бодлогын оновчтой зорилт гэдгийг Дэлхийн банк онцолсныг энд дурдъя.

Хадгаламж, зээлийн хоршоод санхүүгийн зуучлалын нэг хэсэг бөгөөд санхүүгийн хүртээмжийн чухал хөдөлгөгч хүч. Хөгжингүй эдийн засагтай орнууд, ялангуяа Европ, Хойд Америкт болон хөгжиж буй орнуудад санхүүгийн хүртээмжтэй байх үүднээс хадгаламж, зээлийн хоршоодын ач холбогдлыг өндрөөр үнэлж байна. Хадгаламж, зээлийн хоршооны нийт хадгаламж болон зээлийн санхүүгийн системд эзлэх хувь зэрэг стандарт хэмжүүрээр “системийн” ач холбогдол ихэвчлэн бага байдаг хэдий ч хүн амын ядуу давхаргад хүрэх

ач холбогдол, хөдөө орон нутагт өргөн тархсан байдал, олон төрлийн үйлчилгээгээр санхүүгийн хүртээмжийг өргөжүүлэх боломжтой байдал зэрэг нь хадгаламж, зээлийн хоршоодыг үнэ цэнтэй болгож ирсэн.

2017 онд болсон дэлхийн санхүүгийн хямралын дараа ашгийн төлөө ажилладаг олон арилжааны банкууд өрх, аж ахуйн нэгжүүдэд зээл олгохоо хязгаарлах үед санхүүгийн хоршоод гишүүддээ зээл олгохоо үргэлжлүүлсээр байсан. Энэ үед ашгийн төлөө бус хандлага болон гишүүдийн ашиг тусыг нэмэгдүүлэхэд анхаардаг нь хадгаламж, зээлийн хоршоодын нэр хүнд болон тогтвортой байдлыг олон нийтэд дахин баталгаажуулсан.

Монгол Улсад хадгаламж, зээлийн хоршоодын хөгжлийг дэмжих бодлого хангалтгүй байгаа нь алслагдсан орон нутгийн иргэд болон бичил, жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдэд санхүүгийн үйлчилгээг хүргэхэд саад болж байна. Бага орлоготой болон алслагдсан орон нутгийн иргэдэд боломжийн үнээр санхүүгийн цогц үйлчилгээг үзүүлэх нь Монгол Улсын хувьд томоохон сорилт хэвээр байна.

Монгол Улсад санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэхийн тулд хадгаламж, зээлийн хоршоодыг албан ёсны санхүүгийн үйлчилгээ үзүүлдэг бичил санхүүгийн тоглогч болгон хөгжүүлэх хэрэгтэй. Монгол Улсын нийгэм, эдийн засгийн хөгжилд хүлээгдэж буй үүргийг үл харгалзан хадгаламж, зээлийн хоршоодод олон нийтийн итгэх итгэл муу байгаа нь санхүүгийн байгууллагын хувьд сул тал юм. Хадгаламж, зээлийн хоршоодыг бичил санхүүгийн гол тоглогч болгон хөгжүүлэх нэг арга зам нь тэдгээрийг хадгаламжийн даатгалын тогтолцоонд хамруулах бөгөөд иргэдийн итгэлийг нэмэгдүүлснээр эх үүсвэр нэмэгдэж, дагаад зээлийн хүртээмж ч нэмэгдэх боломжтой. Мөн одоогийн хууль эрх зүйн орчиныг олон улсын сайн туршлагад нийцүүлж, санхүүгийн олон төрлийн үйлчилгээг гишүүддээ үзүүлдэг, гишүүдийнхээ нийгэм, эдийн засгийн нийтлэг хэрэгцээг хангадаг, итгэл хүлээсэн, найдвартай, хүчирхэг санхүүгийн байгууллага болгон хөгжүүлснээр улсын хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулж болохыг гаднын туршлагауд харуулж байна.

ЗОХИЦУУЛАЛТЫН МЭДЭЭ

МОНГОЛ УЛСЫН УУЛ УУРХАЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ БИРЖИЙН ӨДӨРЛӨГ БЭЭЖИН ХОТНОО БОЛЛОО



“Монгол Улсын уул уурхайн бүтээгдэхүүний биржийн өдөрлөг” БНХАУ–ын Бээжин хотноо боллоо. Санхүүгийн зохицуулах хороо, Монгол Улсаас БНХАУ–д суугаа Элчин сайдын яам, “Монголын хөрөнгийн бирж” ХК, “Монголын Уул Уурхайн Үндэсний Ассоциаци” ТББ хамтран зохион байгуулсан тус өдөрлөгт уул уурхайн компаниуд, уул уурхайн бүтээгдэхүүний биржийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий зуучлагч компаниуд болон БНХАУ–ын худалдан авагч талууд зэрэг нийт 130 гаруй төлөөлөгч оролцсон юм.



Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан өдөрлөгийг нээж хэлсэн үгэндээ “УИХ–аас ил тод, хариуцлагатай уул уурхай, нэмүү өртөг шингэсэн үйлдвэрлэлийг хөгжүүлж, олон тулгуурт эдийн засгийн бүтцийг бий болгохын зэрэгцээ баялгийн шударга хуваарилалтын зарчмыг хэрэгжүүлэх, эрдэс баялгийн бүтээгдэхүүний гадаад, дотоодын зах зээл дээрх борлуулалтыг нээлттэй, оновчтой, үр ашигтай, зах зээлийн зарчимд нийцсэн аргаар хийх, шударгаар үнэ тогтооход чиглэсэн бодлого, чиглэлийг гаргаж

УИХ, Засгийн газраас шаардлагатай арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэн ажиллаж байгаа билээ. Энэ хүрээнд хийсэн онцлох ажлуудын нэг бол Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийг баталсан явдал юм. Монгол Улсын уул уурхайн бүтээгдэхүүний арилжааг шударга, нээлттэй, ил тод зохион байгуулах, зах зээл дээр бодит үнэ тогтоох боломжтой болох зэрэг үр өгөөжийг шингээсэн эрх зүйн үндэс бий болсон. Санхүүгийн зохицуулах хороо энэ хуулийн дагуу уул уурхайн бүтээгдэхүүний бирж болон биржийн арилжааны зуучлагчдад тусгай зөвшөөрөл олгож үйл ажиллагаанд нь хяналт, зохицуулалт тавьж ажиллахын зэрэгцээ холбогдох дүрэм, журмыг боловсруулан баталж, зохицуулалтын орчныг бий болгоод байна. Ийнхүү уул уурхайн бүтээгдэхүүнийг биржээр арилжаалах нөхцөл бүрдсэнээр салбарын өсөлт, хөгжилд томоохон нөлөө үзүүлэх боломж бүрдсэн. Иймээс цаашид бид биржийн арилжаанд тавих хяналтыг сайжруулах, брокеруудын чадавхыг бэхжүүлэхэд илүүтэй анхаарч, арилжаа эрхлэх байгууллагатай хамтран ажиллаж байна” гэдгийг онцолсон юм.

Энэ үеэр Монгол Улсын уул уурхайн бүтээгдэхүүний биржийн зах зээл, өнөөгийн нөхцөл байдал, хууль эрх зүйн орчин, уул уурхайн бүтээгдэхүүний зах зээлд оролцох боломж, давуу тал, туршлага болон уул уурхайн бүтээгдэхүүний худалдагч компаниудын талаар танилцуулга, мэдээллийг өгсөн бөгөөд цаашид хоёр улсын уул уурхайн салбарын хамтын ажиллагааг өргөжүүлэх, гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын оролцоог нэмэгдүүлэх, уул уурхайн салбарт тулгуурласан экспортын бүтээгдэхүүний өсөлт, энэ салбарын эдийн засагт гүйцэтгэх үүргийг нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой боллоо.

“КОМПЛАЙНСЫН ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭ ХИЙХ АРГАЧЛАЛ” – ҮЙГ ТАНИЛЦУУЛАХ СУРГАЛТ БОЛЛОО

Санхүүгийн зохицуулах хороо зохицуулалтын салбаруудын комплайнсын зохицуулалтын орчныг боловсронгуй болгох зорилгоор “Комплайнсын эрсдэлийн үнэлгээ хийх аргачлал”–ыг энэ онд баталсан. Энэхүү аргачлалыг таниулж, нэвтрүүлэх зорилгоор банк бус санхүүгийн байгууллага, хөрөнгө оруулалтын менежментийн компани, виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч компаниудын эрх бүхий албан тушаалтнуудад “Компанийн засаглалын кодексийн хэрэгжилт, комплайнсын эрсдэлийг үнэлэх нь”

сургалтыг гурав дахь удаагаа зохион байгууллаа. Энэ үеэр байгууллагууд комплайнсын эрсдэлээ үнэлэх аргачлал болон “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилт, мөнгө угаах эрсдэлийн үнэлгээтэй холбоотойгоор дэлгэрэнгүй мэдээлэл хүргэж, оролцогчдын дунд хэлэлцүүлэг өрнүүлэв. Нийт гурван удаагийн сургалтад зохицуулалтын салбарын байгууллагуудын 130 гаруй холбогдох мэргэжилтэн болон эрх бүхий албан тушаалтнууд оролцсон юм.



Комплайнс нь хууль тогтоомж, бизнесийн ёс зүйг дагаж мөрдөх, тэдгээрт нийцсэн үйл ажиллагаа явуулж байгааг хянан баталгаажуулдаг тул комплайнсын эрсдэлийн үнэлгээг хийснээр эрсдэлээ тодорхойлох, түүнээс урьдчилан сэргийлэх, удирдах ач холбогдолтой.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА НАРЫН ЗӨВЛӨЛДӨХ УУЛЗАЛТ БОЛЛОО



Санхүүгийн зохицуулах хороо, Санхүү эдийн засгийн их сургууль /СЭЗИС/-тай хамтран компаниудын Төлөөлөн удирдах зөвлөл /ТУЗ/-ийн нарийн бичгийн дарга нарын дунд зөвлөлдөх уулзалтыг СЭЗИС дээр зохион байгууллаа. Энэ үеэр “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилт,

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нарын компанийн үйл хэрэгт оролцох үүрэг, оролцооны өнөөгийн нөхцөл байдалд хийсэн судалгааны үр дүн мөн цаашдын чиг хандлагын талаар танилцуулж, хэлэлцүүлэг өрнүүлэх замаар харилцан мэдээлэл солилцов.

Энэ удаагийн зөвлөлдөх уулзалт нь компанийн ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нарын үүрэг, оролцоог дээшлүүлэх зорилгоор тулгамдаж буй асуудлуудыг хэлэлцэж, төр, хувийн хэвшлийн харилцан хамтын ажиллагааг бий болгох зорилготой бөгөөд компаниудын ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нар, дотоод аудиторуд болон мэргэжилтнүүд оролцсон юм.

“КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКСИЙН ХЭРЭГЖИЛТ, КОМПАЙНСЫН ЭРСДЭЛИЙГ ҮНЭЛЭХ НЬ” СУРГАЛТ, ХЭЛЭЛЦҮҮЛЭГ БОЛЛОО

Санхүүгийн зохицуулах хороо зохицуулалтын салбаруудын комплайнсын зохицуулалтын орчныг боловсронгуй болгох зорилгоор “Комплайнсын эрсдэлийн үнэлгээ хийх аргачлал”-ыг энэ онд баталсан.



Энэхүү аргачлалыг таниулж, нэвтрүүлэх зорилгоор даатгагч, хөрөнгө оруулалтын менежментийн компани, виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч компаниудын эрх бүхий албан тушаалтнуудад “Компанийн засаглалын кодексийн хэрэгжилт, комплайнсын эрсдэлийг үнэлэх нь” сургалт, хэлэлцүүлгийг зохион байгууллаа. Энэ үеэр байгууллагуудын комплайнсын эрсдэлийг үнэлэх аргачлал болон “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилт, мөнгө угаах, терроризмтай тэмцэх үйл ажиллагаатай холбоотой дэлгэрэнгүй мэдээллийг өгч, оролцогчдын дунд хэлэлцүүлэг өрнүүлсэн юм. Харин дараагийн сургалт хэлэлцүүлгээр итгэлцлийн үйлчилгээ үзүүлэгч банк бус санхүүгийн байгууллага болон виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч компаниудын эрх бүхий албан тушаалтнуудыг оролцуулан зохион байгуулна.

Комплајнс нь хууль тогтоомжийг дагаж мөрдөх, түүнд нийцүүлэн үйл ажиллагаагаа явуулж байгаа эсэхийг баталгаажуулдаг тул комплајнсын эрсдэлийн үнэлгээг хийснээр эрсдэлийг тодорхойлох, түүнээс урьдчилан сэргийлэх, удирдах ач холбогдолтойгоос гадна эрсдэлээс сэргийлэх арга хэмжээний хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлэх боломжтой юм.

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРААС “ЗӨРЧИЛГҮЙ” ДҮГНЭЛТ АВЛАА



Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан Монгол Улсын Ерөнхий аудиторовын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Загджаваас өнгөрсөн оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар “Зөрчилгүй” гэсэн санал, дүгнэлтийг гардлаа. Төрийн аудитын тухай хууль, Төсвийн тухай хуулийн холбогдох заалтуудад заасны дагуу Үндэсний аудитын газар төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний 35 байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэл зэрэгт аудит хийсэн ба Санхүүгийн зохицуулах хорооны төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн аудитаар “Зөрчилгүй” гарсан санал, дүгнэлтийг гардуулан өглөө.

“СТОУС-17” ДААТГАЛЫН ГЭРЭЭГ НЭВТРҮҮЛЭХТЭЙ ХОЛБООТОЙ ТУЛГАМДАЖ БҮЙ АСУУДЛУУДЫГ ХЭЛЭЛЦЛЭЭ

Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөл нь Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт /СТОУС/ 4 “Даатгалын гэрээ”, түүний бүрэлдэхүүн хэсгүүд болон уялдаа холбоог өргөжүүлэх, сайжруулах зорилгоор СТОУС 17 “Даатгалын гэрээ”-г гаргасан бөгөөд уг стандарт 2023 оны нэгдүгээр сараас хэрэгжиж эхэлсэн. Даатгалын салбарт уг стандартыг нэвтрүүлэхтэй холбоотойгоор тулгамдаж буй

асуудал, түүнийг хэрхэн шийдвэрлэх арга замыг тодорхойлох зорилгоор даатгалын салбарын төлөөллүүдийг оролцуулсан хэлэлцүүлгийг Санхүүгийн зохицуулах хороо, Сангийн яам хамтран зохион байгууллаа. Хэлэлцүүлэгт Санхүүгийн зохицуулах хорооноос “Даатгалын салбарын өнөөгийн нөхцөл байдал”, Сангийн яамнаас “Даатгалын салбарын нягтлан бодох бүртгэл, СТОУС-17 олон улсад” сэдвийн хүрээнд мэдээлэл өгсөн бол даатгалын компанийн төлөөллөөс уг стандартыг нэвтрүүлсэн сайн туршлагын талаар танилцуулга хийж, санал солилцлоо.

Энэхүү стандарт даатгалын гэрээтэй холбогдох нягтлан бодох бүртгэлийг илүү нарийвчилж, мэдээллийн ил тод байдлыг сайжруулахад чиглэсэн нь даатгалын салбар дахь хөрөнгө оруулагч, даатгуулагчдад мэдээллийг олон улсын стандартын дагуу бодит, нээлттэй хүргэх, мөн гадаадын хөрөнгө оруулалт татах боломжийг бүрдүүлэх ач холбогдолтой юм.

“САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ХӨГЖИЛ БА ИРГЭДИЙН ОРОЛЦОО” СУРГАЛТ ЗАВХАН АЙМАГТ БОЛЖ БАЙНА

Санхүүгийн зохицуулах хороо иргэдийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх зорилгоор “Санхүүгийн зах зээлийн хөгжил ба иргэдийн оролцоо” сургалт хэлэлцүүлэг, өдөрлөгийг орон нутгуудад уламжлал болгон зохион байгуулдаг. Энэхүү удаагийн ээлжит арга хэмжээ Завхан аймгийн Улиастай хотод болж, иргэд, олон нийт, зохицуулалттай этгээдүүд зэрэг 240 гаруй оролцогчдыг хамрууллаа.

Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан хүрэлцэн ирсэн төр, хувийн хэвшлийн төлөөлөлд талархал илэрхийлээд арга хэмжээг нээж хэлсэн үгэндээ Санхүүгийн зохицуулах хороо зохицуулалтын орчныг олон улсын жишигт нийцүүлэн шинэчлэх, бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх, хөрөнгө оруулагчдын татварын таатай орчныг бүрдүүлэх, хөрөнгийн зах зээлийг олон улсын түвшинд гаргах, гадаадын хөрөнгө оруулагчдыг татах чиглэлээр цогц арга хэмжээг авч ажилласан талаар мэдээлэл өгөв. Түүнчлэн бодлого зохицуулалт, төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны үндсэн дээр санхүүгийн зах зээлд банкны салбар 5 хувийг, банкнаас бусад санхүүгийн салбар 95 хувийг эзэлдэг байсныг зохистой харьцаанд оруулж, одоогийн байдлаар санхүүгийн зах зээлийн нийт хөрөнгө, зах зээлийн үнэлгээ дотоодын нийт бүтээгдэхүүний 24.9 хувьтай тэнцэхүйц хэмжээнд хүрснийг цохон тэмдэглэв. Сургалт, хэлэлцүүлгийн үеэр хөрөнгийн зах зээлийн бодлого зохицуулалт, өнөөгийн нөхцөл байдал, зохицуулалтад



шинээр ороод буй уул уурхайн бүтээгдэхүүний бирж болон мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах хууль эрх зүйн орчин, зах зээлийн нөхцөл байдал, даатгалын салбарын зохицуулалтын орчны шинэчлэлт, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, иргэд, олон нийтэд тулгардаг нийтлэг асуудал, санхүүгийн залилан, луйвраас хэрхэн сэргийлэх талаар мэдээлэл хүргэлээ. Түүнчлэн Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв, үнэт цаас болон даатгалын компаниуд, банк бус санхүүгийн байгууллагын төлөөлөл оролцож, бүтээгдэхүүн үйлчилгээгээ танилцуулах, иргэдэд үнэт цаасны данс нээх, хэрхэн хувьцаа эзэмшигч болох талаар зөвлөгөө мэдээллийг өгч ажиллалаа.

“ТОГТВОРТОЙ БАЙДАЛ, ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН ТАЙЛАГНАЛ” –ЫН ТАЛААР ХЭЛЭЛЦЭВ

Санхүүгийн зохицуулах хороо, ТоС Холбоо, Монголбанк хамтран “Тогтвортой байдал, хүрээлэн буй орчин, уур амьсгалын тайлагнал” сэдэвт хэлэлцүүлэг, арга хэмжээг зохион байгууллаа. Дэлхий даяар хурдацтай хувьсан өөрчлөгдөж буй тогтвортой байдал, хүрээлэн буй орчин, уур амьсгалын тайлагналын стандартуудын чиг хандлага, хэрэгжилтийн талаар мэдээлэл өгч, энэ хүрээнд учирч буй бэрхшээл, туршлагаа солилцох, хэрхэн хамтран ажиллах талаар хэлэлцэх зорилготой хэлэлцүүлэгт санхүүгийн салбарын байгууллагууд, мэргэжлийн холбоод, ТоС холбооны гишүүн байгууллагууд болон хөрөнгийн биржид бүртгэлтэй ТОП компаниудын удирдлага, холбогдох ажилтнууд оролцлоо.

Дэлхийн улс орнууд эдийн засгаа тогтвортой, ногоон хөгжлийн зам руу өөрчлөх шилжилтийг хийж, тогтвортой санхүүжилтийн тогтолцоог бүрдүүлэхэд анхаарал хандуулан ажиллаж байгаа энэ үед бид мөн хамтын ажиллагааныхаа хүрээнд ногоон хөрөнгийн зах зээлийг цогцлоож, тогтвортой санхүүжилтийн тогтолцоог бүрдүүлэх чиглэлийг баримталж ажиллана. Энэ

хүрээнд олон нийт, хөрөнгө оруулагчдад шаардлагатай мэдээлэл, ногоон санхүүгийн хэрэгсэл, бүтээгдэхүүн, бонд зэргийг гаргах зөвлөмжийг тухай бүрд нь өгч, тогтвортой байдал, БОНЗ–ын тайлагналын ач холбогдлыг компаниудад ойлгуулах, мөрдлөг болгоход тууштай хамтран ажиллана” гэдгийг онцолсон юм.

Хэлэлцүүлгийн үеэр тогтвортой байдлын тайлагналын хэрэгжилт, ач холбогдол, тайлагналыг нэвтрүүлж буй компаниудад зөвлөмж мөн БОНЗ–ын үнэлгээ, тайлагналын цахим платформын танилцуулга, ISSB стандарт, тэдгээрийн олон улс дахь хэрэгжилт, ахиц, компаниудад зориулсан тайлагналын хэрэгслүүд болон уур амьсгал, хүрээлэн буй орчны эрсдэл ба тайлагналын талаар мэдээлэл өгч, хэлэлцүүлэг өрнүүллээ.



БАЙР СУУРЬ

МӨНГӨН ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЭТГЭЭДЭЭС ОЛГОХ ЗЭЭЛИЙН ХҮҮГИЙН ДЭЭД ХЭМЖЭЭГ ТОГТООЛОО

Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийг бүртгэх үйл ажиллагаа болон зээлийн хүүгийн дээд хэмжээг тогтоосон талаар Банк бус санхүүгийн байгууллагын газрын дарга Б.Итгэлсүрэнтэй ярилцлаа.



Аймаг, нийслэлийн Засаг дарга дээр хэчнээн иргэн, хуулийн этгээд бүртгүүлсэн байгаа вэ? Бүртгүүлэх хүсэлтийг хэрхэн хүлээн авч байгаа вэ?

Орон нутагт нийт 12 аймагт 114 мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийг бүртгэсэн байна. Үүнээс 79 этгээд нь байнга, ашиг олох зорилгоор зээлийн үйл ажиллагаа эрхлэх иргэнээр, 35 нь барьцаалан зээлдүүлэх журмаар олгох мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдээр бүртгүүлсэн байна. Орон нутагт үйл ажиллагаа явуулах хүсэлтэй иргэд, 100.0 сая төгрөг хүртэлх хувь нийлүүлсэн хөрөнгөтэй хуулийн этгээдийг харьяа аймгийн Засаг дарга бүртгэнэ. Бүртгүүлэх хүсэлтийг Санхүүгийн зохицуулах хорооны Цахим бүртгэлийн системээр эсхүл цаасаар хүлээн авч байна.

Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хууль хүчин төгөлдөр хэрэгжиж эхлээд жил гаруй хугацаа өнгөрлөө. Хуулийн хэрэгжилтийн явцын талаар мэдээлэл өгөөч?

Санхүүгийн зохицуулах хорооноос Мөнгөн зээлийн үйл ажиллагааны бодлогын зөвлөлийн ажиллах журам болон мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийг бүртгэх, тэдгээрээс тайлан, мэдээ хүлээн авах зэрэг үйл ажиллагааг зохицуулах холбогдох журмуудыг батлан, хэрэгжүүлэн ажиллаж байна. Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуульд заасны дагуу мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх хүсэлт гаргасан этгээдийг Санхүүгийн зохицуулах хороо болон аймаг, нийслэлийн Засаг дарга нар бүртгэх үйл ажиллагаа явагдаж байна. 2024 оны 5 дугаар сарын байдлаар улсын хэмжээнд нийт 204 мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийг эрх бүхий байгууллагууд бүртгэсэн байна. Мөн Мөнгөн зээлийн үйл ажиллагааны бодлогын зөвлөлөөс зээлийн хүүгийн дээд хязгаар болон мөнгөн зээлийн үйл ажиллагаанд ашиглах зээлийн, барьцааны, батлан даалтын гэрээний ерөнхий загвар, зээлийн хүү тооцох аргачлалыг батлаад байна.

Улаанбаатар хотод мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх хүсэлтэй иргэд, 300.0 сая төгрөг хүртэлх хувь нийлүүлсэн хөрөнгөтэй хуулийн этгээдийг нийслэлийн Засаг дарга бүртгэхээр хуульчлагдсан боловч 2023 оны 12 дугаар сарын 07-ны өдөр Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт өөрчлөлт орсноор Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч нь хуульд заасан зарим чиг үүргээ хэрэгжүүлэх бүрэн эрхээ Улаанбаатар хотын Ерөнхий менежер, эсхүл дүүргийн Засаг даргад гэрээний үндсэн дээр шилжүүлэх боломжтой болсон. Хуулийн энэ зохицуулалтын хүрээнд Нийслэлийн Засаг даргын 2024 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн А/87 дугаар захирамжаар мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийг бүртгэж, бүртгэлийн гэрчилгээ олгох эрхийг дүүргийн Засаг дарга нарт шилжүүлсэн. Иймд дээр дурдсан иргэд, хуулийн этгээдүүд харьяа дүүргийн Засаг даргад хүсэлтээ гарган бүртгүүлнэ. Дүүргийн Засаг дарга нар мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийг бүртгэж эхэлсэнтэй холбогдуулан Санхүүгийн зохицуулах хорооны 2024 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн 162 дугаар тогтоолоор “Мөнгөн зээлийн үйл

ажиллагаа эрхлэх этгээдэд хувийн дугаар олгох журам”-ыг шинэчлэн батлаад байна. Бүртгүүлэх хүсэлтийг мөн адил Санхүүгийн зохицуулах хорооны Цахим бүртгэлийн системээр эсхүл цаасаар хүлээн авч байна. Одоогоор нийслэлийн 2 дүүрэгт нийт 32 хуулийн этгээд, 3 иргэнийг мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдээр бүртгэсэн байна.

Санхүүгийн зохицуулах хороонд ямар нөхцөл, шаардлага хангасан иргэд, хуулийн этгээд бүртгүүлэх хүсэлтээ гаргах вэ?

Тус Хороо нь орон нутагт 100.0 сая төгрөг, түүнээс дээш, Улаанбаатар хотод 300.0 сая төгрөг, түүнээс дээш хувь нийлүүлсэн хөрөнгөтэй мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх хүсэлтэй хуулийн этгээдийг бүртгэхээр хуульд заасны дагуу бүртгэх үйл ажиллагааг явуулж байна. Өнөөдрийн байдлаар Санхүүгийн зохицуулах хороо 55 барьцаалан зээлдүүлэх журмаар олгох мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийг бүртгэсэн байна.

Мөнгөн зээлийн үйл ажиллагааны бодлогын зөвлөлөөс зээлийн хүүгийн дээд хязгаарыг тогтоосон талаар дурдсан, хүүгийн хувь хэмжээг хэрхэн тогтоосон бэ, хэзээнээс хэрэгжиж байгаа вэ?

Мөнгөн зээлийн үйл ажиллагааны бодлогын зөвлөл 2024 оны 01 дүгээр сарын 18-ны өдөр хуралдаж мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдээс олгох зээлийн хүүгийн дээд хэмжээг сарын 4.5 хувь буюу жилийн 54 хувиар тогтоосон. Мөн энэ хурлаар зээлийн, барьцааны, батлан даалтын гэрээний ерөнхий загвар, зээлийн хүүгийн хэмжээг бодох, тооцох аргачлалыг баталсан. Тус хуралдаанаар баталсан зээлийн хүүгийн дээд хэмжээ болон гэрээний загваруудыг 2024 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөхөөр шийдвэрлэсэн. Зөвлөл хүүгийн дээд хэмжээг тогтоохдоо холбогдох судалгаа шинжилгээнд үндэслэн олон улсын


аргачлалыг ашигласнаас гадна зээлдэгч мөнгө хүүлэлт, өрийн дарамтад орохгүй байх, тэдгээрийн эрх ашиг хамгаалагдах нөхцөлийг бүрдүүлэхийг зорьсон болно. Тухайлбал, “Үүлэн технологи” ХХК-ийн бүтээсэн “Procreditor” программд бүртгэгдсэн барьцаалан зээлдүүлэх журмаар олгох мөнгөн зээлийн үйл ажиллагаанд хамаарах зээлийн багц болон Сангийн яамны “ebalance.mof.gov.mn” системд илгээсэн компаниудын санхүүгийн тайланд судалгаа шинжилгээ хийсэн. Харьцуулсан судалгааны зарим үр дүнгээс дурдвал, дийлэнх улс орнууд мөнгөн зээлийн үйл ажиллагаанд зээлийн хүүгийн дээд хязгаар тогтоохдоо хууль батлах замаар бодлогын зохицуулалтуудыг хийдэг ба Нидерланд, Өмнөд Африк, АНУ-ын зарим мужууд жилийн 50.0–60.0 хувийн, Канад, Эстони, Малайз, Солонгос, БНХАУ зэрэг орнууд жилийн 20.0–36.0 хувийн хүүгийн дээд хязгаарыг тогтоосон байна.

Зээлийн хүүгийн дээд хэмжээг хэтрүүлсэн тохиолдолд хариуцлагын ямар арга хэмжээ тооцох вэ?

Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэгч нь тогтоосон хүүгийн дээд хэмжээг зөрчиж зээлийн гэрээ байгуулсан бол зээлийн хүүгийн дээд хэмжээнээс хэтэрсэн дүнгээр хүү авах эрхээ алдана. Мөн зээлийн хүүгийн дээд хэмжээнээс хэтрүүлэн хүү төлсөн бол илүү төлсөн дүнг үндсэн зээлийн төлбөрт тооцон суутгана, зээлийн төлбөрийг бүрэн суутгасны дараах үлдсэн хэсгийг зээлдэгчид эргүүлэн олгохоор хуульд заасан байдаг. Мөн Зөрчлийн тухай хуульд энэ төрлийн зөрчилд таван зуун нэгжээс таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгохоор тогтоосон байна.

Бидэнд дэлгэрэнгүй мэдээлэл өгсөн танд баярлалаа

Баярлалаа. Та бүхний ажилд амжилт хүсье.



ТОГТВОРТОЙ САНХҮҮЖИЛТ

ТЕКСТИЛИЙН САЛБАРТ ОЛГОХ БОЛОМЖТОЙ ОЛОН УЛСЫН НОГООН САНХҮҮЖИЛТИЙН ЭХ ҮҮСВЭРҮҮД

ТоС Холбооны Монголын ногоон санхүүжилтийн эх үүсвэрийн судалгааны хэсгээс

1. GOOD FASHION FUND (GFF)

GFF нь өндөр үр нөлөө бүхий үйлдвэрлэлийн технологийг санхүүжүүлэх замаар Ази тив дэх текстил болон бэлэн хувцасны салбарт системтэй өөрчлөлтийг бий болгох зорилготой санаачилга юм. GFF-ийг FOUNT байгууллага удирддаг ба FOUNT нь хөгжиж буй орнуудад их хэмжээний хөрөнгө оруулалт хийж, хөрөнгийн удирдлагын мэдлэг туршлагыг бий болгохоос гадна Fashion for Good гэх дэд зөвлөх байгууллагатай хамтран салбарын болон технологийн мэдлэг, хамтын ажиллагааны боломжуудыг санал болгодог.

Санхүүжүүлэгч: Нидерландын засгийн газар

Сангийн хэмжээ: Боломжит санхүүжилт 19 сая ам.доллар, зорилтот сангийн хэмжээ нь 60 сая ам.доллар

Цар хүрээ: Бүс нутгийн хэмжээнд

Гол зорилтот салбар, чиглэлүүд:

- Сайн усны чанар
- Сайн эрчим хүч
- Эдийн засгийн сайн чадавх
- Сайн материал, түүхий эд
- Амьдралын сайн чанар

Санхүүжилтийн хэмжээ: 1–5 сая ам.доллар, томоохон хэлцлүүд дээр синдикат зээл олгох боломжтой.

Санхүүжилтийн хугацаа: Долларын урт хугацаат санхүүжилтэд 5 хүртэлх жил, хамгийн дээд тал нь 7 хүртэл жил. Шаардлагатай тохиолдолд үндсэн төлөлтөөс чөлөөлөх хугацаа тогтоож болно.

2. ДЭЛХИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨӨХ ФРАНЦЫН САН (FFEM)

Дэлхийн байгаль орчны төлөөх Францын санг нийтийн

барааг хамгаалах, олон улсын нийтлэг эрх ашиг, хөгжиж буй орнуудад инновацыг хөгжүүлэх замаар тогтвортой хөгжлийг бий болгох зорилготойгоор 1994 онд Франц Улсын засгийн газраас санаачлан үүсгэн байгуулсан. Уг сан нь биологийн олон янз байдал, уур амьсгал, олон улсын усны болон хөрсний доройтол, химийн бодисын бохирдол, агаар мандал дахь озоны давхарга зэрэг талбаруудад инновацлаг шийдлүүдийг хөгжүүлэх, нэвтрүүлэхийг зорьдог.

Санхүүжүүлэгч: Франц Улсын засгийн газар

Сангийн хэмжээ: 2019–2022 оны хооронд сангийн нийт нөөц 120 сая евро орчим байсан. Сангийн хэмжээ нь улсын төсвийн циклийг даган 4 жил тутам шинэчлэгдэж байдаг.

Хамрах хүрээ: Үндэсний хэмжээний төрийн байгууллагууд, орон нутгийн засаг захиргаа, бүсийн хэмжээний төрийн байгууллага, хувийн хэвшил, ашгийн бус болон иргэний нийгмийн байгууллагууд, нөхөрлөлийн статустай байгууллагууд, олон улсын байгууллагууд.

Гол зорилтот салбар, чиглэлүүд:

- Биологийн олон янз байдлыг хамгаалах, сайжруулах;
- Тогтвортой ой, хөдөө аж ахуйн зориулалттай газар;
- Далайн экосистемийн тэсвэртэй байдал;
- Эрчим хүчний шилжилт, тэсвэртэй хотууд;
- Бүтээгдэхүүний амьдралын мөчлөг, бохирдол, хог хаягдал.

Санхүүжилтийн хэмжээ: Сангийн буцалтгүй тусламжийн хэмжээ нь нэгж төсөлд 500,000–3,000,000 еврогийн хооронд хэлбэлздэг.

Санхүүжилтийн хугацаа: Сангаас хамтын санхүүжилт авсан төслүүд нь 5 жилээс хэтрэхгүй хугацаанд хэрэгжих ёстой бөгөөд зайлшгүй тохиолдолд тайлбар, үндэслэлийг албан ёсоор хүргүүлж болно.

3. ТЕКСТИЛИЙН СУДАЛГААНЫ ЦЮРИХ САН

Текстилийн судалгааны Цюрих сан нь текстилийн салбарын хөгжил, судалгааг дэмжих зорилготой байгууллага юм. Текстилийн салбарын хүрээнд түүхий эд тариалалт, бэлтгэл, боловсруулалт, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл, эдгээр процесст ашиглагдах машин, тоног төхөөрөмж зэргийг хамруулан авч үздэг.

Буцалтгүй тусламжийн хэмжээ: 100,000 швейцарь франк.

Текстилийн судалгааны Цюрих сан нь төслийн шалгаруулалтад дараах 2 чиглэлийг баримталж, дараах асуултыг тавьдаг:

- Текстилийн үйлдвэрлэлд ямар тогтвортой байдлын шийдэл шаардлагатай байгаа вэ?
- Дижитал, цахим хөгжлөөр дамжуулан текстилийн үнэ цэнийн сүлжээг хэрхэн илүү хялбар бөгөөд үр ашигтай болгож болох вэ?

4. ADAPTATION FUND (AF) – ДАСАН ЗОХИЦОХ САН

Дасан зохицох сан нь 2010 оноос хойш 923.5 сая ам.доллартой тэнцэх төсөл, хөтөлбөрүүдийг санхүүжүүлээд байна. Энэ нь 100 гаруй улс, хөгжиж буй орны 15 жижиг арлын улс, 30 буурай хөгжилтэй орон, тэдгээрийн 36 сая гаруй хүнд шууд ашиг хүртээжээ. Түүнчлэн дасан зохицох сан нь өөрсдийн итгэмжлэгдсэн байгууллагуудаар дамжуулан улс орнуудыг санхүүжилт авах, төсөл хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлдэг.

Санхүүжүүлэгч: Дасан зохицох сан нь засгийн газрууд, хувь donорууд (Герман, Швед, Итали, Испани, Бельги, Норвеги, Швецарь, Франц, Их Британи)–аас болон Цэвэр хөгжлийн механизмын хүрээнд гарсан “Certified Emission Reductions (CERs)”–д бүрэлдсэн хөрөнгийн 2 хувиар сангийн хөрөнгийг бүрдүүлдэг.

Сангийн эх үүсвэр: 1,243.11 сая ам.доллар

Хамрах хүрээ: Үндэсний хэмжээний төрийн байгууллагууд, орон нутгийн засаг захиргааны байгууллагууд, бүсийн хэмжээний төрийн байгууллага, хувийн хэвшил, ашгийн бус болон иргэний нийгмийн байгууллагууд, нөхөрлөлийн статустай байгууллагууд.

Санхүүжилтийн хэмжээ:

- Жижиг хэмжээний төсөл, хөтөлбөрүүд – 1 сая ам.доллар;
- Ерөнхий төсөл, хөтөлбөрүүд – 1 сая ам.доллар ба түүнээс дээш.

5. ДАСАН ЗОХИЦОХ САНГИЙН УУР АМЬСГАЛЫН ИННОВАЦЫН ХУРДАСГУУР (AFClA)

AFClA нь Мадрид хотноо болсон НҮБ–ын Уур амьсгалын өөрчлөлтийн бага хурлын үеэр хөгжиж буй орнуудын уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох үйл ажиллагааг инновацаар дамжуулж хурдасгах 10 сая ам.долларын сантай хурдасгуур хөтөлбөрийг нээсэн. AFClA–ийн санхүүжилтийг засгийн газар, төрийн бус байгууллагууд, нөхөрлөлийн бүлгүүд, залуу инновацид болон бусад эмзэг бүлгүүдэд олгох боломжтой.

Сангийн хэмжээ: 10 сая ам.доллар

Хамрах хүрээ: Хөгжиж буй орны ашгийн бус, иргэний нийгмийн байгууллагууд, ТББ–ууд, бизнесийн гишүүнчлэл бүхий байгууллагууд, холбоод, хоршоо ба нөхөрлөлүүд.

Буцалтгүй тусламжийн хэмжээ ба хугацаа: НҮБ–ын Хөгжлийн хөтөлбөр нь 10–15 бичил буцалтгүй тусламжийн санхүүжилтийг олгодог. Үүнд:

- Шинэ/туршилтын инновацлаг дасан зохицох арга туршлага, бизнес модель, технологийг дэмжих (2 жилийн цикл тутамд 60,000 ам.доллар);
- Өргөжүүлэх боломжтой шинэ/туршилтын инновацлаг дасан зохицох арга туршлага, бизнес модель, технологийг хурдасгах чиглэлд 5–10 газарт буцалтгүй тусламж олгодог (2 жилийн цикл тутамд 125,000 ам.доллар);
- Эхний циклд санал болгосон төслийн үр дүнг биелүүлсэн буцалтгүй тусламжийг хүлээн авагчид 2 дугаар циклийн хүрээнд нэмэлт санхүүжилт авах боломжтой (4 жилийн хугацаанд бичил төслүүдэд нийтдээ 120,000 ам.доллар, жижиг төслүүдэд нийтдээ 250,000 ам.долларын санхүүжилт).

6. АГРО–БИЗНЕСИЙН ХӨРӨНГИЙН САН (ABC FUND)

ABC Fund нь хөгжиж буй орнуудын ЖДҮ агро–бизнесүүд, бичил фермүүдийг дэмжих зорилготой нөлөөллийн (impact) сан юм. Сан нь үйл ажиллагаагаараа дамжуулан хөдөө орон нутгийн эмэгтэйчүүд, залуучуудад ажлын байр шинээр бий болгож, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох шийдэлд суурилсан тогтвортой хөдөө аж ахуйн санаачилгуудыг дэмжиж байна.

Гол зорилтот салбар ба чиглэлүүд:

- Бичил фермийн аж ахуй, жижиг ба дунд агро–

- бизнесүүдийн зах зээлийн оролцоог нэмэгдүүлэх;
- Үнэ цэний сүлжээн дэх гол саад бэрхшээлүүдийг тодорхойлох, шийдвэрлэх;
- Баталгаажуулалт, мөшгөх тогтолцоо, экспортын нэмүү өртгийг дээшлүүлэх;
- Уур амьсгалыг даган өөрчлөгдөж сайжирдаг (climate-smart) хөдөө аж ахуйн технологи, инновацыг дэмжих.

7. УУР АМЬСГАЛ БА ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨХ ГОЛЛАНДЫН САН (DFCD)

Уур амьсгал ба хөгжлийн төлөөх Голландын сан нь хөгжиж буй орны уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах болон дасан зохицох чиглэлтэй төслүүдийг санхүүжүүлэх хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх зорилготой.

DFCD-г Уур амьсгалын сангийн менежерүүд (CFM), Нидерландын олон улсын байгаль орчны сан (WWF-NL), Нидерландын хөгжлийн байгууллагын хамтарсан консорциум болон Нидерландын хөгжлийн банк (FMO)-аар удирддаг.

Сан нь 3 тусдаа боловч үйл ажиллагаагаараа хоорондоо холбоотой дэд сангуудаас бүрдэх бөгөөд дэд сан тус бүр нь өөр өөр зорилтот салбартай, төслийн амьдралын мөчлөгт гүйцэтгэх үүрэг нь өөр өөр байна.

- Эхлэлийн сан (Origination facility)
- Газар ашиглалтын сан
- Усны сан

Санхүүжүүлэгч: Нидерландын гадаад хэргийн яам

8. АЗИ ТИВИЙН ХУВИЙН ХЭВШЛИЙГ ДЭМЖИХ КАНАДЫН УУР АМЬСГАЛЫН II САН

2017 онд үүсгэн байгуулагдсан Ази тивийн хувийн хэвшлийг дэмжих Канадын уур амьсгалын II сан нь бага болон дундаас бага орлоготой орнууд, дундаас дээд орлоготой Ази, Номхон далайн жижиг арлын хөгжиж буй орнууд уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах болон дасан зохицох үйл ажиллагаа явуулахад хувийн хэвшлийг оролцуулах зорилготой, 200 сая канад долларын хэмжээтэй сан юм. Тус сангаас дэмжлэг авсан төслүүд жендерийн эрх тэгш байдлыг хангах, охид эмэгтэйчүүдийг чадавхжуулах чиглэлд ажиллах шаардлага тавьдаг.

Сангийн хэмжээ: 200 сая канад доллар

Хамрах хүрээ: Хувийн хэвшил

Уур амьсгалын зорилт: Дасан зохицох, сааруулах, аль алинд хамаарах

Санхүүжилтийн механизм: Хөнгөлөлттэй зээл, техник туслалцаа

9. ХӨДӨӨ АЖ АХУЙН ХӨГЖЛИЙН ОЛОН УЛСЫН САН (IFAD)

Хөдөө аж ахуйн хөгжлийн олон улсын сан (IFAD) нь Ром хотод байрладаг НҮБ-ын хүнс, хөдөө аж ахуйн хаб бөгөөд олон улсын санхүүгийн байгууллага юм. Уг сан нь 1978 оноос хойш 23.2 тэрбум ам.доллартой тэнцэх буцалтгүй тусламж болон бага хүүтэй зээлийг 518 сая хүнийг хамарсан олон тооны төслүүдэд зарцуулаад байна. IFAD нь хөдөө орон нутгийн иргэдийн хүнсний аюулгүй байдлыг сайжруулах, хүнсний тэжээллэг байдлыг нэмэгдүүлэх, орлогоо өсгөхөд нь зориулж хөрөнгө оруулдаг.

Гол зорилтот салбар, чиглэл:

- Targeting;
- Мэдлэгийн менежмент;
- Инновац;
- Хөдөө, орон нутгийн аж ахуйн нэгж;
- Хөдөө, орон нутгийн санхүүжилт;
- Уур амьсгалын өөрчлөлт;
- Нутгийн уугуул иргэдийн оролцоог хангах;
- Газар ба газар ашиглалтын аюулгүй байдлыг сайжруулах;
- Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн төлөөх салбарын хэмжээний үйл ажиллагаа;
- Жендер;
- Засаглалын хорооноос боловсруулсан журам, шаардлага, бодлоготой уялдуулан бусад чиглэлүүдийг хамруулах боломжтой.

Санхүүжилтийн механизм: Буцалтгүй тусламж, зээл (төрийн байгууллага, дэд засаг захиргаа, хувийн хэвшил, бусад байгууллагад олгох зээл), өрийн тогтвортой байдлын механизм, хувьцааны санхүүжилт.

Буцалтгүй тусламжийн хэмжээ:

Жижиг хэмжээний буцалтгүй тусламж: 500,000 ам.доллар хүртэл

Том хэмжээний буцалтгүй тусламж: 500,000 – 3.5 сая ам.доллар

Санхүүжилтийн хугацаа: 3–5 жил.

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ, КОМПЛАЙНС

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДЭРГЭДЭХ ХОРООД

- Төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ)-ийн дэргэдэх хороод нь ТУЗ-д тодорхой чиглэлээр зөвлөгөө өгдөг.
- ТУЗ-ийн дэргэдэх хороод нь компанийн засаглалын салшгүй хэсэг бөгөөд үйл ажиллагааны чиглэл, тайлагналын журамтай байх ёстой.
- ТУЗ-ийн дэргэдэх хороод нь тодорхой чиг үүрэг хариуцах бөгөөд хорооны дарга нь хороодын үйл ажиллагааг үр дүнтэй удирдан, зохион байгуулах ёстой.

ТУЗ нь тухайн жилийн зорилго, үйл ажиллагааны төлөвлөгөөнд үндэслэн хороодыг байгуулж болох бөгөөд хороод нь ТУЗ-ийг зорилгодоо хүрч ажиллахад тусалдаг. Мөн гишүүдэд давхардсан үүрэг хариуцлага ногдуулахгүй байх үүднээс хороодын бүрэлдэхүүн болон гишүүдийн тоонд тогтмол хяналт тавих хэрэгтэй.

Тогтмол үйл ажиллагаа явуулах байнгын хороо эсхүл тодорхой зорилгоор тогтоосон хугацаа, хүрээнд ажиллаж, тухайн зорилгодоо хүрсэн тохиолдолд татан буулгах боломжтой түр хороо (ажлын хэсэг)-г байгуулж болно. Хороодын үйл ажиллагааг хороодын дарга нар удирдан манлайлж, ТУЗ-ийн зорилгыг хэрэгжүүлж ажиллахад нь дэмжлэг болж, чиглүүлэх үүрэгтэй.

Дараах хороодыг түгээмэл байгуулдаг байна. Үүнд:

- Санхүүгийн хороод;
- Харилцаа, хамтын ажиллагааны хороод;
- Аудитын хороод;
- Засаглалын хороод (хүний нөөц болон ТУЗ-ийн үйл ажиллагаанд чиглэсэн);
- Нэр дэвшүүлэх хороод.

ТУЗ-ийн дэргэдэх хороодтой байх ач холбогдол

ТУЗ нь хороодоор дамжуулж үйл ажиллагааныхаа тодорхой чиг үүргийг хэрэгжүүлэх боломжтой. Тухайлбал, засаглал, дотоод асуудал, гадаад харилцаа гэх зэргээр тусгайлсан чиг үүргийн хүрээнд ажиллах боломжтой байдаг.

ТУЗ-ийн хэрэгцээ, шаардлагаас шалтгаалан хороодын бүтэц, бүрэлдэхүүнийг тодорхойлж болох ч, хэдий олон хороо

байгуулна төдий чинээ олон хурал хийх шаардлагатай гэдгийг анхаарах нь зүйтэй. Хороодын гишүүдийг сонгохдоо ажлын туршлага, ур чадварыг анхаарч үзэх хэрэгтэй бөгөөд ТУЗ-ийн гишүүн бүр доод тал нь нэг хороонд ажиллах хэрэгтэй боловч хоёроос илүүгүй хороонд ажиллах нь зохимжтой.

Хороодын зүгээс өгсөн мэргэжлийн зөвлөгөө, зөвлөмжийг ТУЗ-өөр хэлэлцэх бөгөөд нөгөө талаас ТУЗ тухайн зөвлөмжийг заавал хэрэгжүүлэх үүрэг хүлээдэггүй.

Хороодын үр дүнтэй ажиллах үндсэн нөхцөл нь дараах байдлаар илэрдэг байна. Үүнд:

- Тодорхой зорилго, зорилготой;
- Хороодын даргатай;
- ТУЗ-ийн үйл ажиллагааны зорилгод нийцэж, гишүүд нь цаг хугацаа зарцуулах шаардлагатай хүлээн зөвшөөрсөн;
- Хороод нь зөвлөгөө өгөх үүрэгтэй бөгөөд шийдвэр гаргадаггүй гэдгийг ойлгодог;
- Үйл ажиллагаагаа үнэлдэг аргачлалтай.

Компаниудын хувьд жил бүр хороодыг шинээр байгуулдаг бөгөөд энэ нь үйл ажиллагааны тогтмол хэв шинж буюу зогсонги байдлаас сэргийлж, шаардлагагүй хороодыг тухай бүр татан буулгах боломжийг олгодог.

Зарим ТУЗ-ийн хувьд хороод байгуулах шаардлагагүй гэж үзэн, үүрэг даалгаврыг ТУЗ-ийн гишүүдэд хуваарилдаг боловч тухайн ТУЗ-ийн гишүүн маш их үүрэг, хариуцлага хүлээх хэрэгтэй болдог байна.

ТУЗ-ийн дэргэдэх хороод байгуулах давуу тал

Өнөө үед тулгарч буй хамгийн эмзэг асуудлын нэг бол гүйцэтгэх удирдлагын цалин хөлсний асуудал бөгөөд энэ чиглэлээр ажилладаг хороо нь сайн засаглалын чухал бүрэлдэхүүн хэсэг гэж тооцогддог байна.

Түүнчлэн, хороод нь аливаа асуудалд олон талын өнцгөөс хандсан байр суурийг илэрхийлж, улмаар ажлын уялдаа холбоог сайжруулан, ТУЗ-ийн ачааллыг бууруулдаг ач холбогдолтой.

Эх сурвалж: www.thecorporategovernanceinstitute.com

ФИНТЕК БА РЕГТЕК

БАЙГАЛЬД ЭЭЛТЭЙ 10 ШИЛДЭГ ФИНТЕКИЙН ЧИГ ХАНДЛАГА

Эхлэл нь 1-р нүүрт



9 ДИЖИТАЛ ТӨЛБӨР ТООЦОО БА ГАРЫН ҮСЭГ

Өнөөгийн дижитал эрин үед дижитал төлбөр тооцоог өргөнөөр нэвтрүүлж байгаа нь уламжлалт банкны салбарт


өөрчлөлт авчирч байна. Энэхүү өөрчлөлтөд цахим гарын үсэг болон мобайл банкны сонголтууд чухал үүрэг гүйцэтгэж, уламжлалт банкны үйл ажиллагааны байгаль орчны ул мөрийг эрс багасгасан. Түүгээр ч зогсохгүй банкны үйл ажиллагааг цахимжуулснаар банкны оффис, салбар нэгжийн цаасны хэрэглээ мэдэгдэхүйц буурсан байна. Дижитал банк руу шилжих энэхүү шилжилт нь хэрэглэгчдийн тав тухыг нэмэгдүүлээд зогсохгүй илүү ногоон ирээдүйг бий болгоход хувь нэмэр оруулж байна.



8. НОГООН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

Сүүлийн жилүүдэд дэлхийн ногоон хөрөнгө оруулалт ихээхэн нэмэгдэж 2022 онд нийт санхүүжилт 495 тэрбум ам.долларт хүрсэн байна. Энэхүү өсөлтөд байгальд ээлтэй

санаачилгуудыг дэмжихэд чухал үүрэг гүйцэтгэж буй дижитал платформууд болон финтек компаниуд туслалцаа үзүүлсэн. Тогтвортой төслүүдийг санхүүжүүлэх хүсэл эрмэлзэл улам бүр эрчимжиж Green Investment Group, Green Investment Partners зэрэг байгаль орчинд ээлтэй санаачилгуудыг санхүүжүүлэх чиглэлээр мэргэшсэн хөрөнгө оруулалтын байгууллагууд улам бүр түгээмэл болж, банкны хөрөнгө оруулалтын байгууллагууд ногоон хөрөнгө оруулалтын багцыг дэмжсээр байна.



7. НҮҮРСТӨРӨГЧИЙН ХЯНАЛТ

Хэрэглэгчдийн худалдан авалтын нүүрстөрөгчийн нөлөөллийг мэдэх хэрэгцээг хангахын тулд нүүрстөрөгчийн хяналтын технологийг

нэвтрүүлсэн. Банк болон бусад санхүүгийн байгууллагууд нүүрстөрөгчийн ялгаруулалтын хийг хянах технологийн үнэ цэнийг илүүд үзэж байгаагаас Ecolytiq зэрэг финтек компаниудын үйл ажиллагаа тэлж байна. Хэзээ нэгэн цагт тухайн бүтээгдэхүүний байгаль орчинд ээлтэй үнэ цэнийг нь мөнгөн үнэлэмжтэй нь адил чухалчилна гэж гарааны бизнес эрхлэгчид найдаж байна. Нэмж дурдахад блокчейн гэх мэт дижитал шийдлүүд нь CO2 ялгаруулалтыг бодит цаг хугацаанд хянах боломжийг олгож, бизнесүүдэд нүүрстөрөгчийн ул мөрийг үр дүнтэй удирдах, байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг бууруулах арга хэмжээ авах боломжийг олгодог.



6 НҮҮРСТӨРӨГЧИЙН ДҮЙЦҮҮЛЭЛТИЙН СИСТЕМИЙН (CARBON-OFFSET- TING) ГАР УТАСНЫ ТӨЛБӨРИЙН ШИЙДЭЛ

Сүүлийн хэдэн жилийн хугацаанд нүүрстөрөгчийн дүйцүүлэлтийн системийн гар утасны төлбөрийн шийдлүүд түгээмэл болж байна. Эдгээр үйлчилгээ нь хэрэглэгчдэд сэргээгдэх эрчим хүчний төслүүдийг дэмжих эсвэл мод тарих замаар худалдан авалт хийж нүүрстөрөгчийн ялгаруулалтыг бууруулах боломжийг олгодог. TreeCard, Doconomy зэрэг гар утасны программууд нь хүмүүст нүүрстөрөгчийг хянах, байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг бууруулах замаар байгальд ээлтэй шийдвэр гаргах боломжийг олгож, уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг хүчин чармайлтад хувь нэмрээ оруулдаг.



5. НҮҮРСТӨРӨГЧИЙГ ТЭНЦВЭРЖҮҮЛЭХ (CARBON-NEUTRAL) ТӨЛБӨР БОЛОВСРУУЛАХ АРГУУД

Нүүрстөрөгчийн дүйцүүлэлтийн гар утасны төлбөрийн шийдэлтэй адил нүүрстөрөгчийн ялгаруулалтыг тэнцвэржүүлэхийн тулд төлбөрийн боловсруулалтын аргууд ажилладаг. Тэд үүнийг сэргээгдэх эрчим хүчний төслүүдэд хөрөнгө оруулалт хийх замаар хийдэг. Эдгээр төслүүдийг нүүрстөрөгчийн ул мөргүй болгохын тулд төлбөрийн процессуудад зориулж хийсэн. Эрчим хүчний хэмнэлттэй технологи, сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийг ашигласнаар эдгээр аргууд нь төлбөрийн боловсруулалтын байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг бууруулдаг. Switch2Zero зэрэг компаниуд байгаль орчинд ээлтэй янз бүрийн санаачилгад үзүүлэх нөлөөллийг дүйцүүлэхийн тулд бизнесүүдэд Pay-as-you-Go шийдлүүдийг санал болгодог.

4 БАЙГАЛЬ ОРЧИНД ЭЭЛТЭЙ ТЭЭВРИЙН ЗАЙНЫ ТӨЛБӨРИЙН ХЭРЭГСЭЛ



Зайны төлбөрийн хэрэгсэл нь тогтвортой байдлыг хангах, ялангуяа тээврийн салбар дахь финтекийн гол чиг хандлага юм. Энэхүү шинэчлэл нь нийтийн тээврийн үйлчилгээнд бэлэн мөнгө болон цаасан тасалбар авах шаардлагагүй болж, картын төлбөр тооцоог хялбархан гүйцэтгэх замаар цаасны хэрэглээг бууруулж, бэлэн мөнгөний хэрэгцээнээс салгасан байна. Одоо зайны төлбөрийн шийдэл нь Lime гэх мэт дугуй, скүүтэр түрээслэх үйлчилгээнд ажиллаж, байгальд ээлтэй тээврийн сонголтыг дэмжиж, хотуудад тээврийн хэрэгслийн утааг бууруулж байна.

3. БАЙГАЛЬ ОРЧИНД ЭЭЛТЭЙ ДИЖИТАЛ ХЭТЭВЧ



Ухаалаг гар утасных шиг дижитал хэтэвч нь зайны төлбөртэй адил гар утасны төхөөрөмжөөрөө дамжуулан төлбөр хийх боломжийг хэрэглэгчдэд олгодог. Энэ нь зөвхөн

цаасны хэрэглээг бууруулаад зогсохгүй бодит кредит болон дебит картаас үүсэх хуванцар хог хаягдлыг бууруулдаг. Хүмүүс өөрсдийн тав тухыг хангах үүднээс гар утасны хэтэвчийг сонгох нь ихсэх тусам байгальд ээлтэй амьдралын хэв маягийг баримталж, сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр, тогтвортой дэд бүтцийг дэмжсээр байна.



2. БАЙГАЛЬ ОРЧИНД ЭЭЛТЭЙ КРИПТОВАЛҮТ

Сүүлийн жилүүдэд олон криптовалютууд байгаль орчинд ээлтэй илүү тогтвортой практикт анхаарлаа хандуулж, олборлолтын уламжлалт аргуудаас татгалзаж, баталгаатай загвар руу шилжсэн. Кripto олборлолтын

эрчим хүч их шаарддаг шинж чанар нь салбарынхны санаа зовох асуудал байсаар ирсэн. Ethereum зэрэг тэргүүлэгч платформууд нь 'proof-of-work' протоколоос 'proof-of-stake' протокол руу шилжиж, эрчим хүчний хэрэглээг 99.9% хүртэл бууруулсан. Баталгаажуулах алгоритмууд нь зөвшилцлийн механизмтай хослуулан криптовалютын зах зээлд оролцож буй хүмүүст байгальд ээлтэй хөрөнгө оруулалтын боломжийг санал болгож байна.



1. НЭЭЛТТЭЙ БАНК

Нээлттэй банк нь илүү байгальд ээлтэй ирээдүй рүү чиглэсэн финтекийн хөгжлийн тэргүүлэх салбар гэдгээрээ онцлог юм. Европын холбооноос 2018 онд PSD2-ийг баталснаар гуравдагч этгээдтэй мэдээлэл хуваалцах шаардлагатай болсон. Энэ нь өрсөлдөөнийг дэмжих, ил тод байдал, санхүүгийн хяналтыг дэмжих дижитал экосистемийг бий болгож, хэрэглэгчдийг банкаар дамжуулан шинэлэг үйлчилгээ, хувийн туршлагыг бий болгох боломжийг үүсгэсэн. Түүнчлэн, нээлттэй банк нь банкны мэдээллийг

хүн бүрд нээлттэй болгож, санхүүгийн системийг холбож, үр ашигтай болгодог. Энэхүү шилжилт нь тогтвортой байдалд онцгой анхаарал хандуулж, банкууд болон харилцагчдыг байгальд ээлтэй арга барилыг нэн тэргүүнд тавихыг дэмжиж байна.

Эх сурвалж: <https://fintechmagazine.com/top10>

СУДЛААЧИЙН ИНДЭР

Судалгааны ажлын үргэлжлэл /судалгааны ажлын эхлэлийг сэтгүүлийн 4 дүгээр сарын дугаарт нийтэлсэн/

ДЭЛХИЙН ЗАХ ЗЭЭЛ ДЭХ ЗЭСИЙН ҮНЭД НӨЛӨӨЛӨГЧ ХҮЧИН ЗҮЙЛС

Энэхүү судалгааны ажилд дурдагдсан санал, дүгнэлт нь зөвхөн хувь судлаачдын байр суурийг илэрхийлэх бөгөөд Санхүүгийн зохицуулах хорооны албан ёсны байр суурийг илэрхийлэхгүй болно.

Гүйцэтгэсэн:

Санхүү эдийн засгийн их сургуулийн төгсөгч Б.Хулан
b19fa1276@ufe.edu.mn

Удирдагч багш: СЭЗИС-ийн ахлах багш Д.Мөнхцэцэг (МА)

ЭМПИРИК АРГА ЗҮЙ

Судалгаанд бид зэсийн үнийн динамикийг судлахын тулд Люткеполийн санал болгосон экзоген хувьсагчтай VAR-X эконометрик загварыг ашигласан. Ингэхдээ загварын тавил, хувьсагчдыг Гузман, Силва нарын судалгаатай нийцтэй байхаар сонгон авлаа. Мөн түүнчлэн энэ судалгаанд хувьсагчид хоорондын хамаарал цаг хугацааны явцад өөрчлөгдөх боломжтой гэж үзсэн ба өгөгдлийн динамик бүтцийн өөрчлөлтийг БайПерроны тестээр тодорхойлсон болно.

Загварын нийцтэй байдал

VAR-X (экзоген хувьсагчтай вектор авторегресс) загвар нь түүхий эдийн үнэд нөлөөлөгч хүчин зүйлийг шинжлэхэд үнэ цэнтэй сонголт байж болно.

Түүхий эдийн үнэд эрэлт нийлүүлэлтийн динамик, макро эдийн засгийн хувьсагчид, геополитикийн үйл явдлууд, цаг агаарын нөхцөл байдал зэрэг янз бүрийн хүчин зүйл нөлөөлдөг. VAR-X загвар нь түүхий эдийн үнэд үзүүлэх нөлөөллийг илэрхийлэхийн тулд эдгээр хүчин зүйлсийг зэрэг экзоген байдлаар оруулах, эндоген хувьсагчдын харилцан үйлчлэлийг шинжлэх боломжийг олгодог. VAR-X загварт экзоген хувьсагчдыг оруулснаар эдгээр хүчин зүйлсийн өөрчлөлт нь түүхий эдийн үнэд хэрхэн нөлөөлж байгааг үнэлэх боломжтой. Энэ нь хувьсагчдын хоорондын хамаарал, динамикийн талаар илүү дэлгэрэнгүй, нарийн ойлголтыг өгдөг. Түүнчлэн VAR-X загвар нь олон хувьсагчийн нэгэн зэрэг харилцан үйлчлэлд дүн шинжилгээ хийх боломжийг олгодог. Түүхий эдийн үнэ нь ихэвчлэн харилцан уялдаатай байдаг бөгөөд нэг барааны өөрчлөлт бусад бүтээгдэхүүнд нөлөөлдөг.

Эдгээр харилцан холбоог бий болгодог экзоген хувьсагчдыг оруулснаар систем дэх дам нөлөө болон нөлөөллийн механизмын талаар илүү их ойлголт олж авч чадна. Энэ нь түүхий эдийн үнэ болон тэдгээрийн хөдөлгөгч хүчний хоорондын нарийн төвөгтэй харилцаа, хамаарлыг тодорхойлоход бидэнд туслах юм. Цаашилбал, VAR-X загвар нь экзоген хувьсагчдад тулгуурлан ирээдүйн түүхий эдийн үнийг урьдчилан таамаглах боломжийг ч гэсэн олгодог. VAR-X загварт экзоген хувьсагчдыг сонгохдоо анхааралтай авч үзэж, эдийн засгийн онол, өмнөх мэдлэг, эмпирик нотолгоонд тулгуурлах хэрэгтэй гэдгийг анхаарах нь чухал билээ. Нэмж дурдахад хувьсагчдын хөдөлгөөнгүй байдал, зохих хувиргалтыг үнэлэх, мөн загварын таамаглалыг шалгах нь түүхий эдийн үнийн шинжилгээнд VAR-X загварыг хэрэгжүүлэхэд зайлшгүй шаардлагатай алхам юм.

Экзоген хувьсагчтай вектор авторегресс (VAR-X) загвар

VAR-X загварыг олон тооны хугацааны цувааны хувьсагчдын динамик хамаарлыг шинжлэхэд ашигладаг. Энэ загварт эндоген хувьсагчийн зан төлөвийг түүний хоцрогдсон утгуудаар тайлбарлахын зэрэгцээ экзоген хувьсагчдын нөлөөллийг харгалзан үздэг. Загварын ерөнхий тавил дараах байдлаар илэрхийлэгдэнэ:

$$Y_t = c + A_1 Y_{t-1} + A_2 Y_{t-2} + \dots + A_p Y_{t-p} + BX + e_t \quad (1)$$

- ◆ Y_t – t үеийн эндоген хувьсагч юм
- ◆ $Y_{t-1}, Y_{t-2}, \dots, Y_{t-p}$ – эндоген хувьсагчийн хоцрогдолтой утгууд (хоцрогдол p хүртэл)
- ◆ X_t – t үеийн экзоген хувьсагчдын вектор
- ◆ A_1, A_2, \dots, A_p – эндоген хувьсагчийн хоцрогдолтой утгуудын хоорондын хамаарлыг харуулсан коэффициент матрицууд
- ◆ B – экзоген хувьсагч ба эндоген хувьсагчийн хоорондын хамаарлыг харуулсан коэффициент матриц
- ◆ c – тогтмол
- ◆ e_t – алдааны нэр томъёо буюу t үеийн үлдэгдэл

Вектор авторегрессийн загвар нь дараах урьдач нөхцөлүүдтэй байна.

- Параметруудийн шугаман нөхцөл
- Суурин нөхцөл
- Төгс коллениар хамаарал байхгүй
- Алдааны нэр томъёоны таамаглал
- Экзоген хувьсагчдын экзоген байдал



ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭСЭГ

Энэхүү судалгааны ажилд зэсийн үнэ болон түүнийг тайлбарлагч хувьсагчдын нийт 19 өгөгдлийн 1997 оны 1 сараас 2023 оны 3 сар хүртэлх, сарын давтамжтай, 315 урттай хугацаан цувааг ашиглалаа.

Өгөгдлийн танилцуулга

Олон улсад хийгдсэн судалгааны ажлуудад тулгуурлан зэсийн үнэд нөлөөлөгч хүчин зүйлсийг дараах хувьсагчдаар төлөөлүүлэн авсан болно. Өгөгдлийн бүрдэл нь зэсийн зах зээлийн хувьсагчид, суурь хүчин зүйлс, санхүүгийн хүчин зүйлс, хөрвөх чадварын хүчин зүйлс гэсэн үндсэн 4 хэсэгт хуваагдана.

Хүснэгт. Өгөгдлийн танилцуулга

ТЭМДЭГЛЭГЭЭ		ЗОРИУЛАЛТ		ТАЙЛБАР	ХЭМЖИХ НЭГЖ	ЧИГЛЭЛ
1	SPOT	Зэсийн спот захын бодит үнэ	Зэсийн спот захын үнэ		Тонн тугамд ам.доллар	↑↓
2	FUTURES	Зэсийн фьючерс захын бодит үнэ (3 сарын гэрээ)	Зэсийн фьючерс захын үнэ		Тонн тугамд ам.доллар	↑
3	STOCK	Биржийн эзэмшиж буй нийт зэсийн агуулах	LME, COMEX, Shanghai хөрөнгийн биржүүдийн эзэмшиж буй зэсийн нөөц буюу биржүүдээс зөвшөөрөгдсөн агуулахад хадгалагдаж буй цэвэршүүлсэн зэсийн аграгет хэмжээг хэлнэ.		Тонн	↓
4	LONG_POS	Урт позиц буюу авах гэрээ	Урт позиц гэдэг нь хөрөнгө оруулагч түүхий эдийн үнийг ирээдүйд өмнө гэсэн хүлээлтээр худалдаж авсан гэрээ юм.		1000 тонны гэрээ	↑
5	WT	Илүүдэл спекуляцын индекс	Эрсдэлээс хамгаалах хэрэгцээг хангахад шаардлагатай позицоос хэтэрсэн спекуляцын хэмжүүр юм.		Нэгж	↑↓
6	IP	Дэлхийн үйлдвэржилтийн индекс	Уг индексийг тооцоолоходоо үйлдвэрлэлийн янз бүрийн дэд салбаруудын үйлдвэрлэлийн түвшний талаарх мэдээллийг цуглуулж нэгтгэдэг. Ихэвчлэн суурь жил үйлдвэрлэлийн түвшинд 100 гэсэн утгыг тооцож, дараагийн утгууд нь суурь үетэй харьцуулахад аж үйлдвэрийн үйлдвэрлэлийн өөрчлөлтийг тусгадаг.		Нэгж	↑
7	BDI	Балтик Драй индекс (BDI)	BDI-г далайн салбарын бие даасан гишүүнчлэлийн байгууллага болох Балтын бирж өдөр бүр тооцож нийтэлдэг. Энэ индекс нь янз бүрийн төрлийн хөлөг онгоц, маршрутын өдөр тутмын ачааны үнийг өгдөг хөлөг онгоцны брокеруудын үнэлгээнд үндэслэдэг.		Нэгж	↑
8	ER	Чилийн доллартой харьцах бодит ханш	Чили бол дэлхийн хамгийн том зэс үйлдвэрлэгч, экспортлогчдын нэг бөгөөд энэ нь Чилийн песогийн ханш ам.доллартай харьцуулсан ханш байна.		ам.доллар	↓
9	RISK_AVERS	Эрсдэлээс зайлсхийх индекс	Хөрөнгө оруулагчид эрсдэлтэй хөрөнгөөс зайлсхийх эсвэл бууруулж, илүү найдвартай хөрөнгө оруулалтыг илүүд үзэх хандлагатай байгаа түвшнийг тодорхойлдог. Засгийн газрын бонд (илүү аюулгүй гэж тооцогддог), корпорацийн бонд (илүү эрсдэлтэй гэж тооцогддог) эсвэл хэлбэлзэл багатай хувьсааны эсрэг өндөр хэлбэлзэлтэй хувьцаа гэх мэт өөр өөр эрсдэлтэй хөрөнгийн үнийн хөдөлгөөнийг индексжүүлдэг.		Нэгж	↓
10	EPU	Эдийн засгийн бодлогын тодорхойгүй байдлын индекс	Хэвлэл мэдээллийн хэрэгсэл, эдийн засгийн бодлоготой холбоотой мэдээний нийтлэлээс эдийн засгийн бодлогын тодорхойгүй байдлыг илэрхийлсэн түлхүүр үгсийг тодорхой хугацааны туршид хянаж, нэгтгэх замаар тодорхойлдог.		Нэгж	↓
11	GRP	Геополитикийн эрсдэлийн индекс	1900 оноос хойш Нью-Йорк Таймс, Чикаго Трибюн, Вашингтон Пост сонин мэдээнд үндэслэсэн дайны аюул, терроризм, улс орнуудын хоорондын хурцадмал байдлыг хэмждэг индекс юм.		Нэгж	↑↓
12	SP500	S&P500 индекс	Standard & Poor`s 500 индекс нь АНУ-ын томоохон хөрөнгийн биржид бүртгэлтэй 500 том хувьцаат компанийн гүйцэтгэлийг хэмждэг зах зээлийн нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн индекс юм.		Нэгж	↑
13	WTI	Баруун Техасын газрын тосны индекс	Газрын тосны спот үнэ буюу одоогийн зах зээлийн үнийг илэрхийлдэг индекс юм.		Нэгж	↑
14	VIX	Чикагогийн биржийн (CBOE) хэлбэлзлийн индекс	Чикагогийн опцион хөрөнгийн бирж (CBOE) тооцоолдог бөгөөд S&P 500 индекс дээрх опционуудын үндэст тулгуурладаг. Энэ нь өөр өөр хугацаатай S&P 500 индексийн сонголтуудын үнийг харгалзан үзсэн томъёог ашиглан бүтээгдсэн үзүүлэлт юм.		Нэгж	↑
15	GSCI	Голдман Сакс түүхий эдийн индекс	Дэлхийн хөрөнгө оруулалтын банк, санхүүгийн үйлчилгээний фирм Голдман Саксаас тооцоолдог олон төрлийн түүхий эдийн сагсны гүйцэтгэлийг хэмждэг өргөнөөр хүлээн зөвшөөрөгдсөн жишиг индекс юм.		Нэгж	↑
16	LIBOR	Лондоны банк хоорондын хүү	Лондоны томоохон банкуудын банк хоорондын зах зээл дээр бие биедээ зээл олгоход бэлэн байгаа дундаж хүүг илэрхийлдэг. Үүнийг Евро долларын зах зээл дээр богино хугацааны хүүгийн жишиг хэмжигдэхүүн болгон ашигладаг төдийгүй ам.доллар, англи фунт, евро, япон иен, швейцарь франк зэрэг бусад валютуудад ашиглагддаг.		Хувь	↓
17	M2_EURO	Хятадын бодит мөнгөний нийлүүлэлт	Евро бүсийн M2 нь M1 дээр нэмээд банкнууд дахь богино хугацаат хадгаламжийг багтаасан болно.		Тэрбум ам.доллар	↑
18	M2_CHINA	Европын бодит мөнгөний нийлүүлэлт	АНУ-ын M2 нь M1 дээр нэмээд банкнууд дахь богино хугацаат хадгаламжийг багтаасан болно.		Тэрбум ам.доллар	↑
19	M2_USA	АНУ-ын бодит мөнгөний нийлүүлэлт	Хятадын M2 нь M1 дээр нэмээд банкнууд дахь богино хугацаат хадгаламжийг багтаасан болно.		Тэрбум ам.доллар	↑

Эх сурвалж: Судлаачийн тооцоолол

Дээрх хүснэгтэд өгөгдлийг сонгосон шалтгаан болон өгөгдлийн дэлгэрэнгүй тайлбар, хэмжих нэгжүүдийг нэгтгэв. Түүнчлэн онолын ухагдахуунд дурдагдсан зэсийн үнэд үзүүлэх эерэг, сөрөг нөлөөллийн чиглэлийг сумаар тэмдэглэв. VAR загварчлалын хувьд хувьсагч стационар байх нь чухал нөхцөл байдаг тул үнэлгээнд ашиглагдаж буй нэрлэсэн үзүүлэлтийг бодит дүнд шилжүүлэх нь чухал ач холбогдолтой байдаг. Тиймээс энд байгаа нэрлэсэн үзүүлэлтүүд АНУ-ын хэрэглээний үнийн индекс(CPI) болон үйлдвэрлэлийн үнийн индексээр(PPI) 2023 оноор зэрэгцүүлэгдсэн болно (OECD Data, 2023).

Өгөгдлийн тодорхойлогч үзүүлэлтүүд

Энэхүү хэсэгт банк хоорондын захын хүүгээс бусад өгөгдлүүдийг өмнөх жилийн мөн үетэй харьцуулсан өсөлтийн хувь болгон хувиргаж, тодорхойлогч статистикийг шинжилж, дүгнэлт гаргав. Өгөгдлийг түвшин дээр нь нарийн шинжилснээр зэсийн үнэд үзүүлэгч хүчин зүйлсийн статистик шинж чанартай танилцах боломжтой юм.

Хүснэгт. Статистик үзүүлэлтүүд


ТЭМДЭГЛЭГЭЭ	ДУНДАЖ	МЕДИАН	ХАМГИЙН ИХ	ХАМГИЙН БАГА	СТАНДАРТ ХАЗАЙЛТ
SPOT	8.7864	8.7734	9.9864	8.1453	0.3079
FUTURES	8.7923	8.7906	9.9893	8.1129	0.3054
STOCK	12.6856	12.6913	13.8994	11.0966	0.6437
LONGPOS	11.4874	11.6042	12.3470	10.0906	0.5206
WT	0.2977	0.3250	0.4886	0.0334	0.1157
IP	2.2538	2.2721	3.5582	-0.3567	0.5368
BDI	7.4034	7.2775	9.2913	5.7265	0.6843
ER	6.3812	6.3666	6.8732	6.0223	0.1872
RISKAVERS	1.1124	1.0613	2.0832	0.9083	0.1857
EPU	4.7997	4.7363	6.0806	3.9472	0.5058
GRP	4.5307	4.4969	6.2394	3.6648	0.3667
SP500	7.3777	7.2288	8.4718	6.5925	0.4632
WTI	3.9088	4.0316	4.8969	2.4292	0.5706
VIX	2.9798	2.9902	4.1021	2.2607	0.3556
GSCI	8.2070	8.2031	9.2297	7.2750	0.3920
LIBOR	2.3732	1.7300	6.7900	0.1200	2.1216
M2_EURO	9.0613	8.8665	14.4535	7.1613	1.0921
M2_CHINA	9.2480	9.1946	15.4212	6.1368	1.5986
M2_USA	3.5144	3.6462	5.3958	-1.1712	0.9962

Эх сурвалж: Судлаачийн тооцоолол

Банк хоорондын захын хүүгээс бусад үзүүлэлтүүдийн хувьд мөнгөний нийлүүлэлтүүд хамгийн их стандарт хазайлттай байна. Бодит зэсийн үнүүдийн сарын стандарт хазайлт 0.3 хувьтай байна. Дундаж үнийн хувьд спот, фьючерсийн бодит үнэ хоорондоо маш ойролцоо, бусад статистик шинжүүд нь ижил байна. Зэсийн бирж дэх нөөц болон авах гэрээний дүнгийн өмнөх жилийн мөн үетэй харьцуулсан өсөлтийн дундаж хувь тус тус 12 хувь, 11 хувь байна. Спекуляцын индексийн өсөлтийн хувь маш бага 0.29 хувь байна. Чилийн валютын ханшийн дундаж өсөлт 6.4 хувь байжээ. Эрэлтийн үзүүлэлтүүдээс аж үйлдвэржилтийн индексийн дундаж өсөлт 2.3 хувь, хуурай тээвэрлэлтийн индекс өндөр үзүүлэлттэй 7.4 байна. Эрсдэлээс зайлсхийх индексийн дундаж өсөлт 1.1 хувь байна. Харин тодорхой бус байдлын дундаж өсөлт 4 хувь орчим байна. Санхүүгийн индексийн өсөлтийн хувиуд 3 хувиас 7 хувьтай байна.

Эцэст нь банк хоорондын захын хүүгийн дундаж өсөлтийн хувь 2.37 байна. Эндээс өгөгдлүүдийн өсөлтийн хувь харьцангуй бага стандарт хазайлттай байгааг ажиглаж болж байна. Хамгийн их өсөлттэй үзүүлэлт биржийн нөөц, авах гэрээ зэрэг байлаа. Дараах зурагт өгөгдлийн динамикийг дүрсэлж харуулав. Шинжилгээнд ашиглагдаж буй зарим хувьсагчдын динамикаас харахад тренд, сарын нөлөө, хэт утга зэрэг ажиглагдаж байгаа бөгөөд цаашид өгөгдлийг стационар байгаа эсэхийг нэгж язгуурын тестийг ашиглах нь зүйтэй юм.

Зураг. Өгөгдлийн динамик



Хүснэгт. Нэгж язгуурын тест

ХУВЬСАГЧИД	ТҮВШИН		НАТУРАЛ-ЛОГ		ЛОГ-ЯЛГАВАР	
	t статистик	p статистик	t статистик	p статистик	t статистик	p статистик
SPOT	-3.8450	0.002***	-2.9670	0.0392**	-4.2816	0.001***
FUTURES	-3.8994	0.002***	-3.0939	0.028**	-4.2872	0.001***
STOCK	-2.7992	0.199	-4.0226	0.009***	-2.8253	0.056*
LONGPOS	-2.1550	0.224	-4.1123	0.007***	-3.5833	0.001***
WT	-6.6294	0.000***	-6.5380	0.000***	-3.5785	0.001***
IP	-4.1611	0.001***	-3.8193	0.017***	-4.2532	0.001***
BDI	-3.5699	0.007***	-3.4567	0.009***	-4.4926	0.0003***
ER	-1.5666	0.499	-2.0253	0.5848	-2.7777	0.062*
RISKAVERS	-6.2881	0.000***	-6.0205	0.000***	-4.4819	0.001***
EPU	-1.4254	0.570	-5.4801	0.000***	-4.6250	0.001***
GRP	-7.2571	0.000***	-6.0497	0.000***	-3.9667	0.002***
SP500	0.5453	0.988	-1.6707	0.7621	-3.1376	0.025**
WTI	-2.6411	0.0858*	-2.2996	0.1728	-4.1002	0.001***
VIX	-5.9477	0.000***	-5.5547	0.000***	-4.1002	0.001***
GSCI	-2.3838	0.147	-2.0069	0.2839	-3.9693	0.002***
LIBOR	-4.1611	0.001***	-4.1611	0.009***	-2.8797	0.049**
M2_EURO	-18.0056	0.000***	-9.4922	0.000***	-5.2878	0.000***
M2_CHINA	-18.0010	0.000***	-9.1399	0.000***	-5.2236	0.000***
M2_USA	-9.8933	0.000***	-9.3245	0.000***	-5.2812	0.000***

Тайлбар: Энд *, **, *** харгалзан 10 хувь, 5 хувь, 1 хувийн ач холбогдлыг илэрхийлнэ.

Дээрх хүснэгтээс Дикийн-Фуллер тестийн тэг таамаглал болох хугацаан цувааны өгөгдөлд нэгж язгуур байдаг буюу энэ нь стационар биш гэсэн тэг таамаглалыг няцаах шалгуурыг түвшинд, натурал логарифмчилсан ялгавар аваагүй утгад, ялгавар авсан утгад харж байна. Үүнд өгөгдлийн динамикийг ажиглах замаар тогтмол болон трендтэй эсэхийг харгалзан үзэж шалгуур тавьсан болно. Үр дүнгээс харахад дийлэнх өгөгдөл түвшин дээрээ тэг таамаглалыг няцааж түвшин дээрээ стационар байна. Харин бусад өгөгдлийн хувьд натурал логарифмд шилжүүлэх, өмнөх үетэй нь лог дифференциал авснаар стационар нөхцөлийг хангаж байна.


Үндсэн шинжилгээний хэсэг

Судалгаанд Гузман болон Силвагийн санал болгосон зэсийн зах зээлийн хувьсагчдыг эндоген, түүнд нөлөөлөгч хувьсагчдыг экзоген хэлбэрээр загварчилсан VAR-X загварын үнэлгээг зэсийн үнийн 4 өөр үед хийсэн болно (Guzmán & Silva, 2017). Үр дүнг үнийн мөчлөг, дөрвөн үеийн VAR-X загварын үнэлгээ, зэсийн спот үнэд нөлөөлөгч хүчин зүйлсийн шинжилгээ гэсэн дараалалтайгаар гүйцэтгэх болно.

Үнийн мөчлөг

Зэсийн үнэ нь бүтцийн хувьд ихээхэн өөрчлөгддөг үзүүлэлт тул түүний загварчлалд параметруудийг тогтмол байдлаар үнэлэх нь учир дутагдалтай юм. Иймд хугацааны хувьд хувьсах чанарыг харгалзан үзэж VAR-X загварчлалыг хийхдээ үнийн бүтцийн өөр өөр үеүүдэд шинжлэх нь оновчтой билээ. Судалгаанд үнийн мөчлөгийг Бай-Перроны тестийг ашиглан тодорхойлсон ба мөчлөгийн хугарлын цэгүүд нь зэсийн зах зээл дээрх дараах үйл явдлуудтай давхцсан болно.

Зураг. Зэсийн нэрлэсэн үнэ, ДНБ өсөлт



Загварыг үнэлэх дөрвөн үеийн хугарлын цэгүүд:

I үе: 1997 оны 1-р сараас 2003 оны 7-р сар (67 ажиглалт)

Хятадын өсөлт (2003 оны 8-р сар)

II үе: 2003 оны 8-р сараас 2008 оны 7-р сар (60 ажиглалт)


Санхүүгийн хямрал ба их зохицуулалт (10-р сар 2008)

III үе: 2008 оны 10-р сараас 2016 оны 11-р сар (100 ажиглалт)

АНУ-ын импортын хориг

IV үе: 2016 оны 12-р сараас 2023 оны 3-р сар (76 ажиглалт)


(Alshamari, 2018)



VAR-X загварын үнэлгээ


VAR-X загварын хувьд үнэлгээний үр дүнг диаграмм хэлбэрээр харуулах нь зохистой тул дараах диаграммд ач холбогдолтой хувьсагчдын хамаарлыг зураглан үзүүлэв. Дэлгэрэнгүй үнэлгээг харах боломжтой. Үнэлгээний үр дүнг нэгтгэн дүгнэвэл:

Зураг. Үнэлгээний үр дүнгийн зураглал




Дараах графикт дөрвөн үеийн вариацийн түүхэн задаргааны үр дүнг харуулж байгаа бөгөөд дээрх зураглалтай нийцтэй байна. Цаг хугацааны явцад зэсийн үнийн өөрт үзүүлэх нөлөөлөл багасаж байна. 1,2 болон 3 дугаар үеүдэд спекуляц зэсийн үнэд нөлөөлж байна.



Зураг. Вариаци задаргааны зураглал



III үе: 2008 оны 10-р сараас 2016 оны 11-р сар (100 ажиглалт)



IV үе: 2008 оны 10-р сараас 2016 оны 3-р сар (76 ажиглалт)



Зэсийн үнэд нөлөөлөгч хүчин зүйлс

Удаах хэсэгт зэсийн бодит үнэд үзүүлэх нөлөөг хугацааны дөрвөн үед үнэлснээр шинжилнэ.

Хүснэгт. Зэсийн зах зээлийн үзүүлэлтүүдийн үнэлгээ

ЗЭСИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД				
ТАЙЛБАРЛАГЧ ХУВЬСАГЧ	I-P YE	II-P YE	III-P YE	IV-P YE
	SPOT	SPOT	SPOT	SPOT
SPOT(-1)	-0.6658*** (-0.1856)	-0.0847 (-0.5544)	0.1614 (-0.2446)	-0.1764 (-1.5582)
SPOT(-2)	-0.4409*** (-0.1652)	0.4295 (-0.5292)	-0.3119** (-0.2486)	-0.4623 (-1.9149)
FUTURES(-1)	0.8400*** (-0.1783)	0.6814* (-0.5068)	0.2056 (-0.2307)	0.4294 (-1.5679)
FUTURES(-2)	0.5200*** (-0.1662)	-0.2729 (-0.4898)	0.2094 (-0.2414)	0.4762 (-1.9165)
STOCK(-1)	0.5147* (-0.3291)	-0.0749 (-0.5399)	0.0123 (-0.0458)	-0.0725 (-0.0346)
STOCK(-2)	-0.7790*** (-0.2961)	-0.1898 (-0.5351)	0.0339 (-0.0463)	0.0693 (-0.0245)
LONGPOS(-1)	-0.1768*** (-0.0786)	0.0927 (-0.1704)	-0.1387* (-0.0739)	0.1102* (-0.0609)
LONGPOS(-2)	-0.0792 (-0.0952)	-0.3428** (-0.1533)	-0.0529 (-0.0765)	-0.0319 (-0.0646)
WT(-1)	-0.2850 (-0.1153)	-0.1872 (-0.1569)	0.0518* (-0.0855)	-0.0306 (-0.1601)
WT(-2)	-0.2720** (-0.1382)	0.4075* (-0.2151)	0.1084 (-0.0950)	-0.1672* (-0.1444)

Тайлбар: – Хаалтад тухайн коэффициентын стандарт алдааг бичив. (*),(**), (***) харгалзан 10 хувь, 5 хувь, 1 хувийн ач холбогдлын түвшинд харгалзах коэффициентийг илэрхийлнэ.

Зэсийн зах зээлийн үндсэн хувьсагчдын хувьд зэсийн сайн тайлбарлагч үзүүлэлтүүд болно. Тэдгээрт экзоген хувьсагчид нөлөөлж, шууд бусад зэсийн спот үнэд нөлөөлөх боломжтой. Онолын хэсэгт дурдагдсан хувьсагчдын хамаарлын тэмдэг үнэлгээний үр дүнд нийцтэй байна. Харин хожимдлын хувьд 2 байх нь бүх дөрвөн үеийн үнэлгээнд оновчтой байлаа. Хожимдлын уртын шалгуурын үнэлгээг харах боломжтой. Бидний сонирхож буй спекуляц нь нэг болон хоёрдугаар үед статистик ач холбогдолтойгоор зэсийн үнэд эерэг нөлөө үзүүлж байна.

Хүснэгт. Суурь үзүүлэлтүүдийн үнэлгээ

СУУРЬ ХҮЧИН ЗҮЙЛС ҮЗҮҮЛЭЛТҮҮД				
ТАЙЛБАРЛАГЧ ХУВЬСАГЧ	I-P YE	II-P YE	III-P YE	IV-P YE
	SPOT	SPOT	SPOT	SPOT
IP	0.0244** (-0.0107)	0.0218 (-0.0545)	0.1294** (-0.0582)	-0.0198 (-0.0157)
BDI	0.0166** (-0.0083)	0.14** (-0.07)	0.1216 (-0.1110)	0.0407 (-0.0265)
ER	0.6859** (-0.2842)	-1.3694* (-0.7329)	-0.5883*** (-0.1207)	-0.5107** (-0.2097)

Тайлбар: – Хаалтад тухайн коэффициентын стандарт алдааг бичив. (*), (**), (***) харгалзан 10 хувь, 5 хувь, 1 хувийн ач холбогдлын түвшинд харгалзах коэффициентийг илэрхийлнэ.

Суурь хүчин зүйлсийн хувьд спот зэсийн бодит үнийг харьцангуй сайн тайлбарлаж байгаа бөгөөд ихэнх нөлөө статистик ач холбогдолтой байна.

- Аж үйлдвэржилтийн индексийн хувьд зэсийн биет эрэлтийг адилтгаж авч үзэх бөгөөд биет эрэлт нь зэсийн үнийг 0.02 хувиар өсгөж байна.
- Балтик драй буюу хуурай газрын тээвэрлэлтийн өсөлт нэмэгдсэнээр зэсийн спот бодит үнийг эхний үед 0.02 хувиар өсгөж байна.
- Бодит ханшийн өсөлт нь зэсийн үнийг хүчтэй 0.5 хувиас 0.7 хувиар бууруулж байна Долларын ханш зэсийн үнийн өсөлтийг тайлбарлахад чухал байна.

Хүснэгт. Тодорхой бус байдлын үзүүлэлтүүдийн үнэлгээ

ТОДОРХОЙ БУС БАЙДЛЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД				
ТАЙЛБАРЛАГЧ ХУВЬСАГЧ	I-P YE	II-P YE	III-P YE	IV-P YE
	SPOT	SPOT	SPOT	SPOT
RISKAVERS	-0.29** (-0.12)	0.4433 (-0.5446)	-0.1124 (-0.0752)	0.1086 (-0.1038)
EPU	-0.0514 (-0.0563)	-0.43** (-0.20)	-0.0943** (-0.0357)	-0.0754* (-0.0441)
GRP	-0.0154** (-0.0077)	0.0909 (-0.0876)	-0.0401 (-0.0361)	0.0280** (-0.003)

Тайлбар: – Хаалтад тухайн коэффициентын стандарт алдааг бичив. (*), (**), (***) харгалзан 10 хувь, 5 хувь, 1 хувийн ач холбогдлын түвшинд харгалзах коэффициентыг илэрхийлнэ.

Тодорхой бус байдлын үзүүлэлтийн хувьд спот зэсийн бодит үнийн өсөлтийг тайлбарлахад статистик ач холбогдолтой үе байна.

- Эрсдэлээс зайлсхийх индексийн өсөлт эхний үед ач холбогдолтой, сөрөг нөлөө байна.
- Эдийн засгийн бодлогын тодорхойгүй байдлын өсөлт үнийн өсөлтөд 1 болон 2 дугаар үед ач холбогдолтойгоор сөргөөр нөлөөлж байна.
- Геополитикийн эрсдэлийн өсөлт 1 болон 4 дүгээр үед тодорхойгүй байдалд нөлөөтэй байсан ч сөрөг болон эерэг нөлөөг харуулжээ.

Хүснэгт. Тодорхой бус байдлын үзүүлэлтүүдийн үнэлгээ

САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД				
ТАЙЛБАРЛАГЧ ХУВЬСАГЧ	I-P ҮЕ	II-P ҮЕ	III-P ҮЕ	IV-P ҮЕ
	SPOT	SPOT	SPOT	SPOT
SP500	-0.0370 (-0.1306)	0.3156 (-0.5808)	0.6629*** (-0.1366)	0.4390** (-0.1770)
WTI	1.274*** (-0.10)	1.470*** (-0.415)	7.13*** (-0.1)	1.035*** (-0.89)
VIX	-0.1304** (-0.0618)	-0.0730 (-0.1601)	0.0645 (-0.0437)	-0.1023** (-0.037)
GSCI	0.5347*** (-0.1481)	0.13297*** (-0.0488)	0.0202 (-0.1183)	0.3233** (-0.1536)

Тайлбар: – Хаалтад тухайн коэффициентын стандарт алдааг бичив. (*), (**), (***) харгалзан 10 хувь, 5 хувь, 1 хувийн ач холбогдлын түвшинд харгалзах коэффициентыг илэрхийлнэ.

Санхүүгийн үзүүлэлтийн хувьд спот зэсийн бодит үнийн өсөлтийг тайлбарлахад статистик ач холбогдолтой байна. Санхүүгийн зах зээлийн идэвхжиллийг илэрхийлэх үзүүлэлтүүд ихэнх тохиолдолд үнийн сайн тайлбарлагч болохын зэрэгцээ, үнийн өсөлтөд хүчтэй эерэг нөлөөтэй байна.

- VIX индексийн хувьд 1 болон 4 дүгээр үед статистик ач холбогдолтой байсан ба өсөлт нь зэсийн бодит үнийн өсөлтөд сөргөөр нөлөөлж байна.
- Санхүүгийн зах зээлийн идэвхжил сүүлийн үед зэсийн үнийн сайн тайлбарлагч болж байна.

Хүснэгт. Тодорхой бус байдлын үзүүлэлтүүдийн үнэлгээ

ХӨРВӨР ЧАДВАРЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД				
ТАЙЛБАРЛАГЧ ХУВЬСАГЧ	I-P ҮЕ	II-P ҮЕ	III-P ҮЕ	IV-P ҮЕ
LIBOR	0.0032 (-0.0174)	-0.0761* (-0.0412)	-0.0607*** (-0.0165)	0.0305 (-0.0160)
M2_EURO	0.4513*** (0.1946)	0.9178*** (0.8189)	4.2642*** (0.7449)	1.2316*** (0.2629)
M2_CHINA	0.3307*** (0.1604)	0.7079 (0.6570)	0.2592* (0.1453)	0.2716* (0.1617)
M2_USA	0.1191** (0.0495)	0.2510 (0.1848)	4.0035*** (0.6857)	1.5140*** (0.2567)

Тайлбар: – Хаалтад тухайн коэффициентын стандарт алдааг бичив. (*), (**), (***) харгалзан 10 хувь, 5 хувь, 1 хувийн ач холбогдлын түвшинд харгалзах коэффициентыг илэрхийлнэ.

Хөрвөх чадварын үзүүлэлтүүдийн хувьд зэсийн үнийг сайн тайлбарлагч болж байна. Ялангуяа Европ болон Хятадын мөнгөний нийлүүлэлт ихсэх нь зэсийн үнийг ихэсгэж байна. Хүү нь зэсийн бодит үнэд сөрөг нөлөөтэй байна.

ДҮГНЭЛТ, САНАЛ ЗӨВЛӨМЖ

Манай улс түүхий эд, тэр дундаа зэсийн үнээс ихээхэн хамааралтай үнэ хүлээн авагч жижиг нээлттэй эдийн засагт улс боловч түүхий эд, тэдгээрийн үнэд нөлөөлөгч хүчин зүйлсийг тэр бүр нарийвчлан судалдаггүй байна. Гэвч зэс нь дэлхий дахины гол хэрэглээ болдог учир түүнийг тойрсон судалгаа өргөн хүрээнд хийгдэг бөгөөд түүнд нөлөөлөгч хүчин зүйлсийн хувьд эрдэмтэн, судлаач нар өөр өөр үзэл бодолтой байдаг байна.

Ашигт малтмалын эдийн засагчдын хувьд түүхий эдийн үнийн хэлбэлзлийг голдуу микро эдийн засгийн үндэслэл дээр эрэлт, нийлүүлэлтээс нь хамааруулан тайлбарладаг. Харин макро эдийн засагчид болон санхүүгийн шинжээчид үнийн хэлбэлзлийг макро болон санхүүгийн зах зээлийн үзүүлэлтүүдээр тайлбарлахыг оролддог байна. Хэдий эдгээр судалгаанууд хоорондоо уялддаг боловч нийтлэг шинжээр нь сүүлийн үед хийгдсэн судалгаа одоогоор алга байна. Иймд энэхүү судалгаанд дэлхийн макро эдийн засаг, санхүүгийн хувьсагчдын (ялангуяа хөрвөх чадвар, санхүүгийн спекуляц үйл хөдлөл) зэсийн үнийн төлөв байдалд үзүүлэх нөлөөг задлах оролдлого энэхүү судалгааны ажлаар хийж гүйцэтгэхийг зорилго.

Судалгаанд зэсийн зах зээлийн 5 хувьсагч, 14 гадаад нөлөөлөгч хүчин зүйлийг 1997 оноос 2023 он хүртэл сонгон авч VAR-X буюу экзоген хувьсагчаар өргөтгөсөн вектор авторегрессив загварыг авч үзсэн болно. Шинжилгээний үр дүнд зэсийн үнийн хэлбэлзлийг төдийгүй түүний өөрчлөлтийг тайлбарлахад дан ганц суурь хүчин зүйлс хангалтгүй байгааг олж мэдлээ. Сүүлийн үед зэсийн үнийн өөрчлөлтийн нэлээд хэсгийг макро эдийн засгийн хүчин зүйлс тодорхойлж байна. Ялангуяа дэлхийн томоохон улс орнуудын мөнгөний нийлүүлэлт зэсийн үнэд ач холбогдолтойгоор нөлөөлж байна. Чухал ач холбогдолтой байсан гурван үед (I, III ба IV үе) хүү нь спот зэсийн үнэд шууд нөлөөлсөн бололтой. II үед үнийн бараг гуравны нэг нь түүхий эдийн санхүүгийн зах зээлийн үзүүлэлтүүдээр тайлбарлагддаг. Ялангуяа II үед санхүүгийн спекуляц үйл хөдлөл зэсийн үнэд ихээхэн нөлөөлсөн байна.

Энэхүү судалгааны ажилд бас нэгэн шинэлэг зүйл байсан нь бүтцийн өөрчлөлт байсан юм. Эконометрик шинжилгээний үр дүнд тодорхойлсон зэсийн зах зээлийн гурван хугарлын цэгүүд нь Хятадын өсөлт, санхүүгийн хямрал, АНУ-ын худалдааны хоригтой холбоотой үеүд байсан ба энэхүү бүтэц нь үнийн динамикаас харахад ч мэдэгдэхүйц байна. Цаашид зэсийн үнэ, түүнд нөлөөлөгч хүчин зүйлсийг судлахад хугацааны хувьд хувьсах шинж чанарыг харгалзан үзэх нь чухал ач холбогдолтой гэж үзлээ. Эцэст нь судалгааны үр дүнд зэсийн үнийн динамикийг тайлбарлахад санхүүгийн болон хөрвөх чадварын үзүүлэлтүүд чухал ач холбогдолтой учир зэсийн үнийг загварчилж, прогнолоход санхүүгийн болон хөрвөх чадварын үзүүлэлтүүдийг харгалзан үзэх нь чухал байна.

ИТГЭЛЦЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ГЭЖ ЮУ ВЭ?



”Итгэлцлийн үйлчилгээ” гэж харилцан тохиролцож байгуулсан хөрөнгө итгэмжлэх гэрээнд заасан хугацаанд итгэмжлүүлсэн хөрөнгийг үнэгүйдлээс хамгаалж, түүнийг удирдан үр шим хүртэх боломж олгох үйл ажиллагаа юм.



Итгэмжлэгч:

Хөрөнгөө захиран зарцуулах эрхээ гэрээний үндсэн дээр бусдад шилжүүлэн түүнээсээ үр шимийг хүртэгч



Итгэлцлийн эрхлэгч:

Санхүүгийн хорооноос тусгай зөвшөөрөл авсан хуулийн этгээд.

үйлчилгээ

зохицуулах



Итгэмжлэгч өөрийн хөрөнгийг итгэлцлийн үйлчилгээ эрхлэгчийн өмчлөлд 6 сараас доошгүй байршуулна.



Итгэлцлийн үйлчилгээ үзүүлэх эрхтэй эсэхийг шалгаарай.



2024 оны 1-р улирлын байдлаар санхүүгийн зохицуулах хорооноос уг үйлчилгээ эрхлэх зөвшөөрөлтэй 80 ББСБ үйл ажиллагаа эрхэлж байна.



**САНХҮҮГИЙН
ЗОХИЦУУЛАХ
ХОРОО**

Цуврал №37

Монгол Улсын санхүүгийн хүртээмжийг сайжруулах хөтөлбөрийн хүрээнд

ИТГЭЛЦЛИЙН ХӨРӨНГӨ НЬ ЯМАР ТӨРӨЛ ХЭЛБЭРТЭЙ БАЙЖ БОЛОХ ВЭ?



Мөнгөн хөрөнгө



**Үнэт цаас:
Бонд, Хувьцаа
гэх мэт**



Сангийн хөрөнгө



Үл хөдлөх хөрөнгө



Тухайн ББСБ нь харилцагчдыг өөрийн үйл ажиллагааны онцлог, бизнесийн загвар, нөөц боломжоос хамаарч итгэлцлийн хөрөнгөө ямар хэлбэрээр авах мэдээлэл, нөхцөлөөр хангана.

Итгэмжлэгч нь итгэмжлүүлсэн хөрөнгөө өвлүүлэх, бэлэглэх, захиран зарцуулах зэргээр эрхээ шилжүүлэх боломжтой.

ӨГӨӨЖИЙН ТҮВШИНГ ХАРЬЦУУЛСНААР ХАРВАЛ



Итгэлцлийн үйлчилгээнд юуг анхаарах вэ?

- ⚠ Итгэлцлийн үйлчилгээ үзүүлэх эрхтэй эсэх.
- ⚠ Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан итгэлцлийн үйлчилгээний журамтай танилцах.
- ⚠ Эрсдэлийг итгэмжлэгч өөрөө хариуцахыг анхаарах.
- ⚠ Харилцан тохиролцож, хөрөнгө итгэмжлэх гэрээг байгуулах.
- ⚠ Итгэлцлийн үйлчилгээтэй холбогдох гомдлыг санхүүгийн зохицуулах хороонд мэдэгдэх.



Итгэлцлийн үйлчилгээний
журамтай танилцах



ЗАХ ЗЭЭЛИЙН СУДАЛГАА, ХӨГЖЛИЙН ГАЗАР

ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

ДОУ ЖОНСЫН ИНДЕКС 600-ААС ДЭЭШ ОНООГООР УНАЖ, ЭНЭ ЖИЛИЙН ХАМГИЙН МУУ ӨДӨР БОЛЛО.



2024.05.23-ны өдөр Доу Жонсын индекс 600 гаруй нэгжээр унаж, 2024 оны хамгийн уналттай өдрөөр тодорч, үндсэн гурван индекс бүгд уналттай хаагдсан байна. Хиймэл оюун ухааныг хөгжүүлэгч Nvidia компанийн хувьд 10 хувийн хувьцааны хуваагдал зарласны дараа энэ уналт тохиолджээ.

Энэ үед чип үйлдвэрлэгч Nvidia компанийн хувьцаа мөн 9% -иас илүү өссөн ч гэсэн эдгээр нь зах зээлийн өргөн цар хүрээг хамруулаагүйг харуулж байна. (Nvidia бол Dow Jones Industrial Average-ийг бүрдүүлдэгч топ 30 хувьцаанд багтдаггүй билээ.)

Боинг компанийн хувьцаа 2024.05.23-ны өдөр зах зээл дээр жин дарахуйцаар буюу 7.5%-иар буурсан нь тус нисэх онгоц үйлдвэрлэгч компанийн мөнгөн урсгал энэ онд хүлээгдэж байснаас тааруу байлаа гэж мэдэгдэв.

Тухайн өдөр S&P 500 болон Nasdaq Composite индекс 0.7% болон 0.4%-иар мөн адил буурчээ. Цаашид тавдугаар сард бага зэрэг буурах төлөв ажиглагдсан “Худалдан авалтын менежерүүдийн индекс” өмнөх жилийн зургадугаар сараас хойших хамгийн өндөр буюу 3.5 хувиар өссөний дараа энэ зүйл тохиолдсон нь АНУ-ын эдийн засаг инфляцид баригдахгүй байгаагийн илрэл юм.

Голдман Сакс компанийн гүйцэтгэх захирал Дэвид Солонзон тус өдөр Бостоны коллежид зохион байгуулсан арга хэмжээний үеэр “ХНС энэ жил хүүгээ бууруулж эхлэхгүй байх магадлалтай” гэж илтгэлдээ дурьдсан байна. Төв банкны тухай эдгээр байр суур нь хөрөнгө оруулагчдыг ХНС-аас

хүүгээ бууруулах хүлээлтийг бууруулахад хүргэж болзошгүй байна.

Эх сурвалж: Нью Йорк CNN

ИПОТЕКИЙН ЗЭЭЛИЙН ХҮҮ ГУРАВ ДАХЬ ДОЛОО ХОНОГТОО БУУРЧ, 7 ХУВИАС ДООШ БОЛЛО.



АНУ-д ипотекийн зээлийн хүү гурван долоо хоног дараалан буурсан нь орон сууцны зээлтэй Америкчуудын хувьд сайн мэдээ байлаа.

Стандарт нөхцөлтэй 30 жилийн хугацаатай орон сууцны зээл дунджаар 6.94% байв. Энэ нь 2024 оны 4-р сарын эхэн үеэс хойших хамгийн доод түвшин бөгөөд үндсэндээ 7%-ийн босгоос доогуур орсон үзүүлэлт болжээ.

АНУ-д энэ оны 3-р сард ипотекийн зээлийн хүү буурсны дараа 4-р сарын сүүлээр ипотекийн зээлийн хүү өсч эхэлж байгаа нь эдийн засгийн мэдээллүүдээр энэ оны эхнээс инфляц буурч байгааг зарим талаар харуулж байна. Ипотекийн зээлийн хүү нь АНУ-ын 10 жилийн хугацаатай төрийн сангийн өгөөжтэй уялдаатай бөгөөд энэ нь Холбооны нөөцийн сангийн хүүгийн талаарх хүлээлттэй нягт холбоотой байдаг.

Freddie Mac-ийн ахлах эдийн засагч Сэм Хатер “Ипотекийн зээлийн хүү сүүлийн сар гаруйн хугацаанд анх удаа долоон хувийн босгоос доош унасан тул энэ хаврын орон сууц худалдан авагчдад таатай нөлөөтэй юм” гэж мэдэгджээ.

ХНС-ын зарим албан тушаалтнууд энэ долоо хоногийн эхээр бодлогын хүүгээ дахин өсгөхгүй байх магадлалтай гэж мэдэгдсэн нь ипотекийн зээлийн хүү буурах сайн талтай юм.

Одоогоор АНУ-ын орон сууцны зах зээлийн сэргэлт зогсонги байдалтай байна. Орон сууцны зах зээлийн борлуулалт өнгөрөгч дөрөвдүгээр сартай нийлээд хоёр дахь сар дараалан буурсан гэж Үндэсний риэлторуудын холбоо (NAR) 2024.05.23-нд мэдээллэсэн.

Ипотекийн зээлийн хүү өнгөрсөн жилийн намар сүүлийн хорин жилийн хугацааны дээд цэгтээ хүрч байсан үеэсээ одоо буурсан ч 2022 он хүртэлх сүүлийн 10 жилд байгаагүй өндөр хэвээр л байна.

Өөр нэг зүйл бол сүүлийн саруудад тогтмол нэмэгдэж байгаа хэдий ч эрэлтийг хангахгүй байгаа орон сууцны нийлүүлэлт байнга дутмаг байна. Энэ нь зарим орон сууцны эзэд 2022 онд ХНС хүүгээ өсгөж эхлэхээс өмнө барьж байсан бага ипотекийн зээлийн хүүгээр төлж байгаа учраас байраа зарахгүй байхаар шийдсэнтэй холбоотой юм. Ипотекийн зээлийн хүү өссөөр байгаа тул зарим орон сууцны эзэд байраа зарахгүй байхаар шийджээ.

NAR-ын ахлах эдийн засагч Лоуренс Юн “Орон сууцны зах зээлд үнэхээр тэнцвэртэй байдлыг бий болгохын тулд ойрын хэдэн жилийн хугацаанд 1.6 сая ба түүнээс дээш айлын орон сууцны төслийг хэрэгжүүлэх шаардлагатай” гэж мэдэгджээ. Түүнээс нааш “Орон сууцны хомсдол буурахгүй” гэж хэлсэн. Өөр нэг бэрхшээл бол орон сууцны үнэ маш өндөр хэвээр байгаа бөгөөд олон сая америкчууд, ялангуяа анх удаа орон сууц худалдан авагчид худалдан авч чадахгүй байгаа явдал юм.

NAR-аас 2024.05.22-ны өдөр орон сууцны үнэ он гарсаар эхний 4-р сар үргэлжлүүлэн өссөөр байгаа бөгөөд одоо ч байшингийн дундаж үнэ өмнөх оны мөн үеэс 5.7%-иар өсч 407,600 доллар болсон гэж мэдэгдсэн.

АНУ-ын орон сууцны үнийн өсөлт энэ оны 2-р сард 2022 оны 11-р сараас хойших хугацаанд хурдацтай өссөн гэж S&P CoreLogic Case-Shiller АНУ-ын Орон сууцны үндэсний үнийн индекс мэдээлсэн. Сан Диего, Чикаго, Детройт хотуудад орон сууцны үнэ энэ оны хоёрдугаар сард хамгийн их өсжээ.

Зээлийн өндөр хүү, үнийн өсөлт, зах зээл дээр хангалттай орон сууцны нийлүүлэлт байхгүй зэрэг хүчин зүйл нь орон сууцны зах зээлийг хүндрүүлэхэд хүргэж байна. Ерөнхийлөгч Жо Байден дундаж давхаргын худалдан авагчдад татварын хөнгөлөлт үзүүлэх, орон сууц барих ажлыг дэмжих хууль тогтоомж зэргийг санаачилж, Конгрессын зөвшөөрөл авахаар уламжилсан байна.

Эх сурвалж: Washington CNN

WALMART БОЛОН TARGET КОМПАНИУД БҮТЭЭГДЭХҮҮНИЙХЭЭ ҮНИЙГ БУУЛГАЖ БАЙНА. ЭНЭ НЬ ИНФЛЯЦИД ХЭРХЭН НӨЛӨӨЛӨХ ВЭ?



Walmart 2024 оны 5-р сарын 16-ны өдөр дэлгүүрүүдийнхээ 7000 орчим нэр төрлийн барааны үнийг бууруулахаа мэдэгдсэн байна.

Walmart-ын гүйцэтгэх захирал Даг МакМиллон нь шинжээчидтэй уулзах үеэрээ “Бидний өдөр тутмын хямд үнэ болон буцаалт хийх боломж олгох нь хэрэглэгчдийн хүлээлтэд нийцнэ” гэж мэдэгджээ.

Мөн 2024.05.20-нд угаалгын нунтаг, муурны хоол, нарнаас хамгаалах тос зэрэг 1500 гаруй нэр төрлийн барааны үнийг бууруулж, зуны улиралд хэдэн мянган барааг дахин бууруулах төлөвтэй байна. Тухайлбал, хүүхдийн 16 ширхэг Huggies салфетка 1.19 ам.доллар байсан бол 99 цент болтлоо буурч, Good & Gather брэндийн шарсан самар 6.89 ам.доллараас 5.29 ам.доллар болгож хямдруулжээ.

2024.05.22-нд тус компани сүүлийн нэг жилийн турш нээлттэй байгаа дэлгүүрүүдийн борлуулалт буурсан гэж мэдээлсэн бөгөөд бүтээгдэхүүний үнэ нь зорилтот гол дундаж давхаргын үйлчлүүлэгчдэд дарамт учруулж байна гэж үзсэн тул энэхүү шийдвэр гаргах болсон шалтгаанаа тайлбарласан.

Ikea, Aldi зэрэг бусад жижиглэнгийн худалдаачид ч мөн адил сүүлийн саруудад үнээ бууруулсан байна.

Зарим эдийн засагчид, жижиглэнгийн худалдаачид бүтээгдэхүүний үнийг бууруулсан нь инфляц ерөнхийдөө буурсаны дохио гэж үзэж байгаа ч үлдсэн бусад салбарын инфляц мөн Холбооны нөөцийн сангийн зорилтот 2 хувьд хүрэхийн тулд буурах шаардлагатай байна гэж онцолсон.

Морнингстар компанийн АНУ-ын ахлах эдийн засагч Престон Колдуэлл хэлэхдээ, “том хэмжээний жижиглэнгийн худалдаачид бүтээгдэхүүний үнийг бууруулах нь тустай хэдий ч, бидэнд орон сууцны үнийн инфляц буурах, цалингийн өсөлтийг хэвийн үргэлжлүүлэх нь чухал” гэж тайлбарласан.

Ажилгүйдлийн түвшин түүхэн доод түвшиндээ хэвээр байгаа нь ХНС хатуу бодлогоо зөөлрүүлэх шийдвэр гаргахаасаа өмнө хөдөлмөрийн зах зээлийг илүү бэхжүүлэх байр суурьтай байгаа нь зарим хүмүүсийн хүлээлтийг удаашруулж байна.

Гэсэн хэдий ч сүүлийн үеийн мэдээллээс харахад инфляц

буурах магадлалтай байна. Хөдөлмөрийн статистикийн товчооны мэдээлснээр, 2024 оны 4-р сард хэрэглээний үнэ 3.4%-иар өсөж, өмнөх сарынхаас 3.5%-иар буурсан байна. АНУ-ын эдийн засагт ч “хөрөх” шинж тэмдэг ажиглагдаж байна. Америкчууд цар тахлын дараа зардлаа танаж, зээлээ бууруулж, хуримтлалаа нэмэгдүүлж, илүү хэмнэлттэй болж байна. Жижиглэнгийн борлуулалт энэ оны өнгөрсөн сард зарлага 0.6%-иар буурсан нь хэрэглэгчид зардлаа бууруулж байгаагийн шинж тэмдэг юм.

Эх сурвалж: Нью Йорк CNN




ОЛОН УЛСЫН ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ИНДЕКС

2024 оны 05 дугаар сарын 29-ны өдөр

S&P 500 (^GSPC)


5,306.04 +1.32 (+0.02%)



Эх сурвалж: www.finance.yahoo.com

Nikkei 225 (^N225)


37,818.11 -641.97 (-1.67%)



Эх сурвалж: www.finance.yahoo.com

FTSE 100 (^FTSE)


8,254.18 -63.41 (-0.76%)



Эх сурвалж: www.finance.yahoo.com

NASDAQ Composite (^IXIC)

17,019.88 +99.08 (+0.59%)



Эх сурвалж: www.finance.yahoo.com



Засгийн газрын IV байр, Бага тойруу-3, Чингэлтэй дүүрэг,
Улаанбаатар хот, Монгол Улс 15160



976-51-264444



press@frc.mn



www.frc.mn



Санхүүгийн зохицуулах хороо



@FRC_of_Mongolia

